



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

(Дүрслэх урлаг технологи I-V анги)

Улаанбаатар
2019

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

ГАРЧИГ

ТУШААЛ	4
ӨМНӨХ ҮГ	5
АГУУЛГА	6
I АНГИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ	
1.1 ДҮРСЛЭХ УРЛАГ	10
1.2 ТЕХНОЛОГИ	12
II АНГИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ	
2.1 ДҮРСЛЭХ УРЛАГ	16
2.2 ТЕХНОЛОГИ	18
III АНГИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ	
3.1 ДҮРСЛЭХ УРЛАГ	22
3.2 ТЕХНОЛОГИ	25
IV АНГИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ	
4.1 ДҮРСЛЭХ УРЛАГ	29
4.2 ТЕХНОЛОГИ	32
V АНГИЙН СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ	
5.1 ДҮРСЛЭХ УРЛАГ	39
5.2 ТЕХНОЛОГИ	42



БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/35


Улаанбаатар хот

Суралцахуйн удирдамж батлах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" А/491 дүгээр тушаал, "Хөтөлбөр батлах тухай" А/492 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага боловсролын монгол хэл, математик, хүн ба орчин, хүн ба нийгэм, хүн ба байгаль, дүрслэх урлаг технологи, хөгжим, биеийн тамир, англи хэлний сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг нэгдүгээр; суурь боловсролын монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик биологи, хими, газар зүй, түүх, нийгэм судлал, дүрслэх урлаг, хөгжим, дизайн, технологи, биеийн тамир, англи хэл, орос хэлний сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг хоёрдугаар; бүрэн дунд боловсролын заавал судлах, сонгон судлах монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, нийгэм судлал, англи хэл, орос хэлний болон заавал судлах монголын түүх, биеийн тамир, дизайн зураг зүй, технологи, сонгон судлах түүх, дизайн, технологийн сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын нэг, хоёр, гуравдугаар хавсралтаар батлагдсан суралцахуйн удирдамжийг нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газруудад хүргүүлж, холбогдох мэдээллийг байгууллагын цахим хаяг /mier.mn/-т байршуулахыг Боловсролын хөтөлбөрийн секторын эрхлэгч /А.Энхтогтох/-д даалгасугай.

ЗАХИРАЛ  П.ЛХАГВАСҮРЭН
ХТА2990

ӨМНӨХ ҮГ

Суралцахуйн удирдамж, түүний зориулалт

Суралцахуйн удирдамж нь сургалтын хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг суралцахуй болон багшлахуйгаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг үлгэрчлэн төлөвлөсөн баримт бичиг юм.

Суралцахуйн удирдамж нь сургалтын хөтөлбөрийг жилээр болон нэгж, ээлжит хичээлээр зохистой төлөвлөх, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, хичээлийн арга зүйн санааг хөгжүүлэх, үнэлгээг үр дүнтэй зохион байгуулах хөтөч болно.

Суралцахуйн удирдамж нь арга зүйн зөвлөмж төдий бус, өнөөгийн боловсролын хөгжлийн чиг хандлага, үзэл санаанд суурилсан шинэлэг арга зүйг тусгасан тул суралцахуй, багшлахуйд тулгамдаж буй бэрхшээл, сорилтыг даван туулахад дэмжлэг үзүүлнэ.

Багш суралцахуйн удирдамжийг сайтар ойлгож, мөрдөн хэрэгжүүлэх нь хичээлийг үр өгөөжтэй зохион байгуулах, суралцахуйн үйл ажиллагааг бүтээлчээр дэмжих, багшлах ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Суралцахуйн удирдамжийг багш нар бэлэнчлэн хуулбарлаж хэрэглэх биш, өөрсдийн туршлага, ур чадвараар баяжуулан хөгжүүлэхийн сацуу сурагчдынхаа ялгаатай байдал мэдлэг, чадвар, хандлагад тохируулан уян хатан, нээлттэйгээр хэрэгжүүлэх боломжтой юм.

Суралцахуйн удирдамжийн бүтэц

Суралцахуйн удирдамж нь суралцахуйн зорилт, суралцахуйн үйл ажиллагаа, багшид зөвлөмж, хэрэглэгдэхүүн гэсэн үндсэн бүтэцтэй.

Суралцахуйн зорилт нь сурагчийн эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн илэрхийлэл. Өөрөөр хэлбэл; тухайлсан үйл ажиллагааны үр дүнд сурагчийн эзэмших мэдлэг, чадвар юм.

Суралцахуйн үйл ажиллагаа: Багш төвтэй сургалтын арга зүйг биш, сурагчийн бүтээлч сэтгэлгээ, идэвх, оролцоо, бие даасан байдлыг хүндэтгэн дэмжсэн, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах, эрэл хайгуул хийх зэрэг сурагч төвтэй сургалтын арга технологид суурилсан үйл ажиллагааг тусгасан.

Суралцахуйн зорилт бүрээр сэдэлжих, мэдлэг бүтээх сорил туршилт, дадлага ажил, даалгавар гүйцэтгэх арга, аргачлал, үр дүнгээ үнэлэх, ганцаарчлан болон багаар ажиллах арга зүйн шийдлийг зөвлөсөн болно. Мөн багш суралцахуйг дэмжих, туслах үүрэг, хариуцлагаа ухамсарлах, багийн үйл ажиллагааг хөгжүүлэх, сурсан зүйл нь хүүхэд бүрт “үр өгөөжтэй” байхад санаа тавих, хүүхэд бүрийн суралцах ялгаатай байдлыг харгалзан хичээл зохион байгуулахад анхаарах зүйлийг зөвлөмжилсөн.

Хэрэглэгдэхүүн: Энэ хэсэгт суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хэрэглэх сурах бичиг, гарын авлага, цахим болон бусад эх сурвалж, дадлага, туршилт, аялал, төсөлт хичээл, хамтын хичээлийн хэрэглэгдэхүүнийг сонгон ашиглахыг санал болгосон.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин тус бүрээр боловсруулсан тул сургууль, багш нар судлагдахуунуудын хөндлөн ба босоо залгамж холбоог сайтар судлан хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Боловсролын хүрээлэн

АГУУЛГА

I АНГИ

1.1 ДҮРСЛЭХ УРЛАГ

- 1.1а. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг таньж хэрэглээг тодорхойлох
- 1.1б. Тосон харандаагаар ажиллах арга барилыг зураг дүрслэлд хэрэглэх
- 1.1в. Энгийн хэлбэр дүрс зурахдаа цэглэх, толболох, цэгүүдийг холбох аргыг ашиглах
- 1.1г. Энгийн дүрсээс бүтсэн эд юмсыг дүрслэхдээ шулуун, долгион, нуман, тахир зураасыг хэрэглэх
- 1.1д. Үндсэн 5 дүрсийн нийлэмжийг эд юмсыг дүрслэхдээ ашиглах
- 1.1е. Усан будгаар ажиллах арга барилыг зураг бүтээлдээ хэрэглэх
- 1.1ж. Нэг ба олон өнгөөр зурсан зургийн ялгааг харьцуулах, зураг дүрслэлдээ ашиглах
- 1.1з. Өөрийн бодол төсөөллөөр зурсан зургаас гол ба туслах дүрийг таньж тодорхойлох
- 1.1и. Өөрийн бодол төсөөллөөр зурсан зургаас наана цаана байгаа зүйлсийг таньж тодорхойлох

1.2 ТЕХНОЛОГИ

- 1.2а. Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэх, өрөх аргаар бүтээх
- 1.2б. Үндсэн дүрсийг зохиомжлон наах аргаар бүтээл хийх
- 1.2в. Үндсэн дүрсийг эвлүүлж наах аргыг техникийн загвар бүтээхэд хэрэглэх
- 1.2г. Амьтны ба техникийн загвар бүтээхэд цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж хайчлах аргыг ашиглах
- 1.2д. Цаасыг нугалах аргаар бүтээл хийх
- 1.2е. Навч өрж наах аргаар амьтны дүрс бүтээх
- 1.2ж. Баримлын шавартай ажиллах хэрэглэгдэхүүнийг таньж зориулалтыг тодорхойлох
- 1.2з. Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх аргаар хагас товгор дүрс бүтээх
- 1.2и. Баримлын шаврыг цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох, мушгих аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний загвар хийх

II АНГИ

2.1 ДҮРСЛЭХ УРЛАГ

- 2.1а. Үндсэн өнгийг хольж, үүсмэл өнгүүдийг үүсгэх замаар үндсэн болон үүсмэл өнгийг ялгааг таньж тодорхойлох
- 2.1б. Үндсэн болон үүсмэл өнгийг зураг дүрслэлдээ ашиглах
- 2.1в. Хуруугаар дардаслах аргаар толбо үүсгэн өөрийн бодол төсөөллөөр баяжуулан зурах

- 2.1г. Ургамал, амьтан дүрслэхдээ махир зураасыг хэрэглэх
- 2.1д. Эд юмсыг зурахдаа үндсэн 5 дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөх аргыг ашиглах
- 2.1е. Уншсан зүйлийнхээ агуулгаар зурсан зургаас гол ба туслах дүрийн ялгааг тайлбарлах
- 2.1ж. Давхцуулан зурах аргаар юмсын наана, цаана хол, ойр байршлыг дүрслэн харуулах
- 2.1з. Хоёр өнгөөр дагнааслан будах аргаар цэцэг, навчин хээг дүрслэх
- 2.1и. Чулуун дээр зураас арилгагч (штрих), шохойн ба лааны тосон харандаагаар зураг зурах аргыг хэрэглэх

2.2 ТЕХНОЛОГИ

- 2.2а. Үндсэн дүрсээр нийлмэл дүрс бүтээж харьцуулан тайлбарлах
- 2.2б. Ам дөрвөлжин цаасан нугалаагаар амьтны дүрс бүтээх
- 2.2в. Цаасыг хуйлах, тэнийлгэх аргаар бэлэг дурсгалын бүтээл хийх
- 2.2г. Үндсэн болон нийлмэл дүрсийг эвлүүлж наах аргаар техникийн загвар бүтээх
- 2.2д. Олон дүрс ашиглаж, эвлүүлдэг тоглоом зохион бүтээх
- 2.2е. Ургамал, амьтны дүрс бүтээхэд баримлын шаврыг цаасан дээр нялж наах аргыг ашиглах
- 2.2ж. Баримлын шавар, савх модыг холбох аргаар мал, амьтны загвар хийх, бүрдэл хэсгийг нэрлэх
- 2.2з. Өвс ургамал, навчаар 2 хэмжээст бүтээл хийх
- 2.2и. Өнгө өнгийн чулууг баримлын шавраар холбох аргаар амьтны баримал хийх
- 2.2к. Номын хавчуурга хийхэд төрөл бүрийн материалыг ашиглах
- 2.2л. Шувууны тэжээл бэлтгэхэд цаасан хайрцаг ашиглах

III АНГИ

3.1 ДҮРСЛЭХ УРЛАГ

- 3.1а. Өнгийн хүрдийг ажиглаж дулаан, хүйтэн өнгийг ялгааг таньж тодорхойлох
- 3.1б. Дулаан, хүйтэн өнгийг байгалийн зураг дүрслэлд ашиглах
- 3.1в. Санамсаргүйгээр толбо үүсгэх аргыг зураг дүрслэлдээ ашиглах
- 3.1г. Юмсын хатуу, зөөлөн, тогтвортой, хөдөлгөөнтэй зэрэг шинж чанарыг зураасны төрлүүдээр илэрхийлэх
- 3.1д. Үндсэн дүрсүүдийг дардаслан олшруулах аргаар зохиомжийн ойлголтоо харуулах
- 3.1е. Хүүхдийн зураг, бүтээлүүдээс төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлэх
- 3.1ж. Бодит болон хийсвэр зургийг харьцуулан орон зай илэрхийллийн ялгааг тайлбарлах
- 3.1з. Монголын зураачдын уран зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах
- 3.1и. Гурван өнгөөр дагнааслан будах аргаар эвэр угалз дүрслэх

3.2 ТЕХНОЛОГИ

- 3.2а. Үндсэн ба нийлмэл дүрсийн хэлбэрийг өөрчлөх аргаар загвар бүтээх
- 3.2б. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж загвар бүтээх
- 3.2в. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээх
- 3.2г. Хатуу цаасыг хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны загвар бүтээх
- 3.2д. Цаасыг нугалж хайчлах аргаар тэгш хэмийн ойлголтыг тайлбарлах
- 3.2е. Цаасыг тэгш хэмээр нугалж, хайчлах аргаар техникийн загвар бүтээх
- 3.2ж. Эд ангийг үлгэр ашиглан зурж хайчилж угсрах аргаар техникийн загвар бүтээх
- 3.2з. Байгалийн материалыг зохиомжлон наах, холбох аргаар бүтээл хийх
- 3.2и. Янз бүрийн материалыг будаж хооронд нь холбох, хайчлах, чимэглэх аргаар бүтээл хийх
- 3.2к. Баримлын шавраар хийсэн геометрийн энгийн биетүүдийг өрж холбох аргаар хэлбэрийг өөрчлөх, хувиргах
- 3.2л. Баримлаар хийсэн амьтад, юмсын загварыг зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээх
- 3.2м. Өнгийн ноосон утас ашиглан бөмбөлөг хийх аргаар бүтээл хийх
- 3.2н. Зүүлтийн гоёл чимэглэлд өнгийн ноосон утсыг хатуу цаасанд ороох, цаасны ирмэг дагуу хайчлах, цацагласан утсаа багцалж боох аргыг ашиглах

IV АНГИ

4.1 ДҮРСЛЭХ УРЛАГ

- 4.1а. Өнгийн хүрднээс эсрэг өнгийг байрлалаар нь ялгаж, эсрэг өнгийн ялгарлыг ажиглан тодорхойлох
- 4.1б. Эсрэг өнгийн ялгарлыг зураг дүрслэлдээ ашиглах
- 4.1в. Төрөл бүрийн материалаар толболох аргыг зураг дүрслэлдээ ашиглах
- 4.1г. Хөгжмийн аялгууг сонсоод зураасны төрлүүдээр илэрхийлэх
- 4.1д. Нэг төвт зохиомжийн онцлогийг зураачдын бүтээлийн жишээн дээр тайлбарлах
- 4.1е. Үндсэн дүрс ба биетийг бүтээхдээ орон зайн ялгааг анзаарах
- 4.1ж. Амьтны биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан дүрслэх
- 4.1з. Араг зургийн аргаар амьтдын хөдөлгөөнийг дүрслэх
- 4.1и. Хүүхдийн болон монгол зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах
- 4.1к. Мартан, нагтан зургийн аргаар өөрийн бодол төсөөллийг дүрслэх

4.2 ТЕХНОЛОГИ

- 4.2а. Цаасны үүсэл болон боловсруулах үе шатыг жишээн дээр тайлбарлах
- 4.2б. Цаасан хайрцаг задалж тэгш өнцөгт биетийн дэлгээс судалж тайлбарлах
- 4.2в. Тэгш өнцөгт биетийн дэлгээс байгуулах аргаар тоглоомын загвар бүтээх
- 4.2г. Хавтгай дүрсүүдийг сэтэлж хайчлах аргаар холбож 3 хэмжээст бүтээл хийх

- 4.2д. Төрөл бүрийн биетүүдийг загварчлах аргаар бүтээл хийх
- 4.2е. Туузан цаасыг хэлбэр үүсгэн холбох аргаар 3 хэмжээст чимэглэлийн бүтээл хийх
- 4.2ж. Шигтгэж чимэглэл хийхэд байгалийн материал (будaa, чулуу, самрын яс)-ыг ашиглах
- 4.2з. Цаасыг хэлбэрт оруулж тугалган цаасаар бүрэх аргаар амьтдын баримал урлах
- 4.2и. Хаягдал материалаар хүндрүүлэгч ачаа, харимхай металл салхины хүч ашиглан техникийн загвар бүтээх
- 4.2к. Гар оёдлын багаж хэрэгслийг жижиг эдлэл хийхэд ашиглах
- 4.2л. 2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зууш бэлтгэх
- 4.2м. Ажил мэргэжлийн онцлогийг жишээгээр тайлбарлах

V АНГИ

5.1 ДҮРСЛЭХ УРЛАГ

- 5.1а. Дүрслэх урлагийн төрөл зүйлийг бүтээлийн жишээгээр тайлбарлах
- 5.1б. Өнгийн уламжлалт нэршил, бэлгэдлийг тайлбарлах, нэг өнгийг цайруулах аргыг зураг дүрслэлдээ ашиглах
- 5.1в. Биетийн гэрэл сүүдрийг дүрслэхдээ цэглэх, толболох аргыг ашиглах
- 5.1г. Задгай болон өнцөгглөсөн зохиомжийн ялгааг харьцуулан зураачдын бүтээлийн жишээн дээр тайлбарлах
- 5.1д. Юмсын хол, ойр байршлыг нэг цэгийн алслалттай холбон тайлбарлах
- 5.1е. Юмсын хол, ойр байршлыг хүйтэн дулаан өнгө, хүнд хөнгөн өнгийн ялгаатай холбон тайлбарлах
- 5.1ж. Хүний нүүрний хэсгүүдийн хэмжээ, харьцааг дүрслэх аргыг зураг дүрслэлдээ ашиглах
- 5.1з. Гадаадын зураачдын уран зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах
- 5.1и. Геометрийн дүрсийн гаралтай хээ угалзыг дүрслэх
- 5.1к. Түйхий ба их дагнаасын харьцуулах онцлог, ялгааг тайлбарлах
- 5.1л. Монгол зургийг орон зайтай дүрслэх аргыг жишээн дээр тайлбарлах

5.2 ТЕХНОЛОГИ

- 5.2а. Цаас дахин боловсруулан ашиглах талаар жишээн дээр тайлбарлах
- 5.2б. Цаасыг нугалах, хуйлах аргаар чимэглэлийн загвар хийх
- 5.2в. Нимгэн кардон хуйлж ирмэгээр нь зөрүүлэн наах аргаар цилиндр, конус биет бүтээх
- 5.2г. Цилиндр, конус биетийн бүрдэл хэсгийн тоог нэмэх аргаар загварчилж бүтээл хийх
- 5.2д. Автомашины загварын хэлбэрийг өөрчлөх аргаар зориулалтыг тодорхойлох
- 5.2е. Байгалийн материал (боргоцой, чулуу)-ын хэлбэрийг ашиглан бүтээл хийх
- 5.2ж. Цаасан зуурмагаар баримал, шуумал хийх
- 5.2з. Цаасан тавагны хэлбэрийг өөрчлөх аргаар малгайн загвар бүтээх
- 5.2и. Энгийн гар оёдлын төрлүүдийг зөөлөн эдлэл хийхдээ ашиглах
- 5.2к. 3-4 төрлийн орц найрлагатай хачиртай талх бэлтгэх
- 5.2л. Сургууль дээрх ажил мэргэжлүүдийн нэрлэх онцлог болон нийтлэг талыг жишээгээр тайлбарлах


НЭГДҮГЭЭР АНГИ






1.1 ДҮРСЛЭХ УРЛАГ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.1а. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг таньж, хэрэглээг тодорхойлох	– Сурах бичгээс харандаа, баллуурын барилтыг ажиглах. <i>/Багш зургийн дагуу барьж харуулан дагуулах/</i> – Үндсэн дүрсүүдийг хэв ашиглан зургийн дэвтэртээ зохиомжлон байршуулж, харандаагаар зургийг буулган сумны дагуу хэвтээ, босоо, ташуу чиглэлд шугамгүйгээр багшийг дуурайн зурааслан зурах <i>/Багш самбарт үндсэн дүрсүүдийг зохиомжлон, зураасны чиглэлийг зурж эхлүүлнэ/.</i>	Сурах бичиг, зургийн дэвтэр, харандаа, баллуур, эсгий бал, үндсэн дүрсийн ТӨМ
1.1б. Тосон харандаагаар ажиллах арга барилыг зураг дүрслэлд хэрэглэх	– Тосон харандааны төрлүүдтэй танилцах <i>/Багш хуурай шохойн, тосон, лааны тосон харандааны бодит үзүүлэн үзүүлж ярилцана/.</i> – Сурах бичгээс тосон харандааны барилт, жигд нягт будах аргачлалыг ажиглах <i>/Багш тосон харандааны барилт, даралт, жигд, нягт будалтыг туршиж үзүүлэх, самбарт будах дүрсийн зохиомж зураглал гаргана/.</i> – Үндсэн дүрсийн хэв ашиглан харандаагаар зургийн зохиомж гарган сумны чиглэлийн дагуу тойруулан зурж жигд, нягт, будах дадлага ажил гүйцэтгэх	Сурах бичиг, зургийн дэвтэр, харандаа, баллуур, тосон харандаа, үндсэн дүрсийн ТӨМ
1.1в. Энгийн хэлбэр дүрс зурахдаа цэглэх, толболох, цэгүүдийг холбох аргыг ашиглах	– Цэглэх аргаар дүрс үүсгэн зурахыг ойлгох: <i>/Багш самбарт соронзоор цэгийн байршлыг зохиомжлон, хоорондох зайг шохойгоор цэглэж үзүүлнэ/.</i> – Сурагчид дэвтэртээ цэгүүд үүсгэх – Цэгүүдийг холбоход ямар дүрс үүсэж байгааг ярилцах – Сурах бичигт өгөгдсөн дүрсүүдээс сонгон цэглэх аргаар дүрслэн, өнгийн будгаар дүрсийг жигд таглан будаж, эсгий балаар цэгүүдийг тодотгох	Зургийн дэвтэр, харандаа, баллуур, тосон харандаа, эсгий бал, өнгийн будаг, сурах бичиг
1.1г. Энгийн дүрсээс бүтсэн эд юмсыг дүрслэхдээ шулуун, долгион, нуман, тахир зураасыг хэрэглэх	<i>/Багш самбарт 60х80 цагаан цаасыг соронзоор тогтооно. Эсрэг өнгийн нэхмэлийн утсаар зураасны төрлүүдийг дүрслэн харуулж сэдэлжүүлнэ. Мөн урт, богино, өргөн, нарийн шулуун, тахир зураасны ялгааг дүрслэн таниулна/.</i> – Сурагчид сурах бичигт дүрслэгдсэн уул, тал, мод, байшингийн дүрсээс сонгон дүрсэлж, эсгий балаар өнгө ялган тодруулах	Ватум цаас, өнгийн, нарийн, бүдүүн утас, үдээс, бүс, Зургийн дэвтэр, харандаа, баллуур, эсгий бал, өнгийн будаг, сурах бичиг

1.1д. Үндсэн 5 дүрсийн нийлэмжийг эд юмсыг дүрслэхдээ ашиглах	– Ангид байгаа эд юмс ямар дүрс, хэлбэртэй байгааг ажиглуулан ярилцах <i>/Багш А4 хэмжээтэй таван өнгийн дүрс үзүүлэн ямар зураасаар холбогдсоныг эсрэг өнгийн утас барин татаж харуулна/.</i> – Сурагчид сурах бичгээс дүрс, биетийг харьцуулан ажиглах – Дүрсүүдийг эвлүүлэн зохиомжлон энгийн эд зүйл зурах – Тосон харандаагаар таглан будах дасгалыг зургийн дэвтэртээ гүйцэтгэх	Зургийн дэвтэр, харандаа, баллуур, тосон харандаа, сурах бичиг, А4-н таван дүрс, өнгийн утас
1.1е. Усан будгаар ажиллах арга барилыг турших, зураг бүтээлдээ хэрэглэх	<i>/Багш 6-12 өнгөтэй усан будаг, бөөрөнхий зөөлөн үстэй бийрний ком үзүүлж, хайрцагийг нээгээд харахад өнгүүд нь тод гялалзсан, хурууны өндгийг усанд дүрж норгоод будган дээр хөнгөн дарахад гарт наалдсан цавуулагтай байвал сайн гэдгийг туршин хэлж өгнө. А3-А2-н хавтан дээр ватум цаасыг скочоор хөдөлгөөнгүй байрлуулан, хавтанг молиберт дээр байрлуулан будах дарааллыг туршин харуулна/.</i> – Сурагчид багшийн өгсөн зөвөлгөө, сурах бичгийн аргачлалын дагуу өөрийн дуртай улирлын тэнгэр, уул, газрыг жигд, шингэн таглан будах <i>/Бийрээ усандаа байнга дүрээстэй байлгахгүй, будагтай бийрээ ам, нүдэндээ хүргэж болохгүйг сануулна/.</i>	Хавтан, молиберт, Ватум цаас,скоч, усан будаг, бийр, нойтон сальфетик, усны сав, зургийн дэвтэр, харандаа, баллуур, сурах бичиг
1.1ж. Нэг ба олон өнгөөр зурсан зургийн ялгааг харьцуулах, зураг дүрслэлдээ ашиглах	– Нэг ба олон өнгөөр зурсан хүүхдийн бүтээл <i>/А3/</i> ажиглах – Ялгааг тайлбарлан ярилцах – Байгалийн үзэгдэл, ургамлын дүрсээс сонгон нэг өнгөөр, хүнсний ногоог гурваас дээш өнгөөр ялган будах	Өнгийн будаг, бийр, нойтон сальфетик, усны сав, зургийн дэвтэр, харандаа, баллуур, сурах бичиг
1.1з. Өөрийн бодол төсөөллөөр зурсан зургаас гол ба туслах дүрийг таньж тодорхойлох	– Сурах бичгээс янз бүрийн материал дээр чөлөөт сэдвээр зурсан хүүхдийн бүтээлийг ажиглах ямар материал ашиглан зурсан эсэх, дүр, дүрслэлийн талаар ярилцах – Үзсэн хүүхэлдэйн киноны үйл явдлаас зуруулж, гол ба туслах дүрийг ялгуулан ярилцах	Сурах бичиг, хүүхдийн бүтээл, зургийн дэвтэр, харандаа, баллуур, эсгий бал, өнгийн будаг, бийр, усны сав
1.1и. Өөрийн бодол төсөөллөөр зурсан зургаас наана цаана байгаа зүйлсийг таньж тодорхойлох	– Хүүхдийн бүтээлээс дээд, дунд, доод хэсэгт юу, юу дүрслэгдсэн, хэмжээ нь яаж өөрчлөгдөн зурагдсан ялгааг ажиглан ярилцах – Өөрт таалагдсан сэдвээр зураг зурж, дүрүүд байршлаа олж, зөв зурагдсан талаар сэтгэгдлээ илэрхийлэх	Хүүхдийн бүтээл, зургийн дэвтэр, харандаа, баллуур, эсгий бал, өнгийн будаг, бийр,усны сав,

1.2 ТЕХНОЛОГИ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.2а. Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэх, өрөх аргаар бүтээх	– Ам дөрвөлжин, гурвалжин, гонзгой дөрвөлжин дүрсийг савх модоор, дугуй, зууван дугуй дүрсийг жижиг чулууг эвлүүлэн өрөх аргаар бүтээх – Өнгийн цаасаар ам дөрвөлжин, дугуй, гурвалжин, зууван дугуй, гонзгой дөрвөлжин дүрсийг зураас дагуулан хайчлах аргаар бүтээх, түүнийгээ нэрлэх <i>/Багшийн зөвлөмж: Дугуй, зууван дугуй дүрсийг яаж хайчлах аргыг багшаас биеэр үзүүлнэ. Багшаас Paint программ дээр дүрс зурах чадвар эзэмшсэн байна/.</i>	Д,Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи I. 1 дүгээр ангийн сурах бичиг. УБ., 2017 он. хуудас 16-17 - Өнгийн цаас - Үндсэн дүрсүүд - Савх мод - Цаасны хайч - Жижиг чулуу
1.2б. Үндсэн дүрсийг зохиомжлон наах аргаар бүтээл хийх	- Сурах бичгийн 22-р хуудасны “Боролзгоно” цэцгийн наамлыг яаж ямар үйл ажиллагааны дарааллаар хийсэн болохыг ажиглах - Шар, улаан, ногоон өнгийн цаасаар дугуй дүрсүүд хайчлах - Эхлээд 5 шар дугуйг ногоон дэвсгэрт дээр зохиомжлон наах - Дараа нь улаан дугуй дүрсийг шар дугуй дүрсийн голд наах - Төгсгөлд нь ногоон дугуй дүрсээ сурах бичгийн 22-р хуудасны 2.2 дугаар зургийн дагуу нугалж, хийсэн навчаа 2.3 дугаар зурагт үзүүлснээр наах - Сурах бичгийн 25-р хуудасны 2.11, 2.13 дугаар зурагт харуулсан шиг байгалийн зураг олж бэлтгэх - Байгалийн зураг дээрээ гэр эсвэл байшингийн дүрсийг зохиомжлон наах <i>/Багшаас гэр, байшингийн наамал хийхэд орох дүрсүүдийг урьдчилан бэлтгэсэн байна./</i>	Д,Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи I. 1 дүгээр ангийн сурах бичиг. УБ., 2017 он. хуудас 22-25, 42 - Өнгийн цаас - Үндсэн дүрсүүд - Цаасны хайч - Цаасны цавуу
1.2в. Үндсэн дүрсийг эвлүүлж наах аргыг техникийн загвар бүтээхэд хэрэглэх	- Автобус, ачааны авто машин, тракторын дүрс зургийг ажиглаж нэрлэх - Автобус, ачааны авто машин, тракторын дүрс зураг тус бүрд хэдэн дугуй дүрс, хэдэн ам дөрвөлжин, хэдэн гонзгой дөрвөлжин дүрс байгааг дараах хүснэгтэд нөхөж бичих <i>/Өөр хэмжээтэй нэг ижил дүрсийг хүүхэд ялгахгүй учир багшаас зайлшгүй туслах шаардлагатай. Хэдэн дүрс байгааг эхлээд зураасаар тэмдэглэнэ. Дараа нь цифрээр бичнэ. Ийм төрлийн дасгалыг сурагчид яаж ажиллахыг сурах бичгийн 17-р хуудасны 1.35 дугаар зурагнаас ажиглана/.</i>	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи I.1 дүгээр ангийн сурах бичиг. УБ., 2017 он. хуудас 46,47 - Өнгийн цаас - Үндсэн дүрсүүд - Цаасны хайч - Цаасны цавуу 

	<table><tr><td>Нэр</td><td></td><td></td><td></td></tr><tr><td>Автобус</td><td></td><td></td><td>//// 4</td></tr><tr><td>Ачааны машин</td><td></td><td></td><td></td></tr><tr><td>Трактор</td><td>// 2</td><td></td><td></td></tr></table>  - Автобус, ачааны машин, тракторын загварыг наах - Эхлээд дэвсгэртээ сонгох - Дүрсээ зохиомжлон наах	Нэр				Автобус			//// 4	Ачааны машин				Трактор	// 2			
Нэр																		
Автобус			//// 4															
Ачааны машин																		
Трактор	// 2																	
1.2г. Амьтны ба техникийн загвар бүтээхэд цаасыг голоор нь нугалж хайчлах аргыг ашиглах	- Ам дөрвөлжин өнгийн цаасыг хавсарч нийлүүлэн нугалах - Нугалсан цаасны битүү ам талаас нь сурах бичгийн 38-р хуудасны эрвээхэй, 39-р хуудасны шувууны зургийг зурах <i>/Нугалсан цаасан дээр эрвээхэй, шувууны зургийг багшийн тусламжтайгаар үлгэр хэв ашиглан түүнээ тойруулж зурна/.</i> - Зураасны дагуу хайчилж, эрвээхэйн загварын их биеийг тусад нь хийж наана. Эрвээхэйн далавч, шувууны далавчийг хөдөлгөөнд оруулахын тулд туузалж хайчилсан цаасыг хөндлөн хөндий наах - Туузан цаасны голоос чимхэж татах аргаар далавчийг дээш доош хөдөлгөх - Далавчийг яаж хөдөлгөхийг багш биетээр үзүүлж, сурагчид даган дуурайж хийх - Сурах бичгийн 74-р хуудасны цаасыг давхарлаж хайчлах аргаар машин яаж бүтээснийг ажиглах - Эрвээхий, шувууны загварыг цаасаа яаж давхарлаж хайчилсан тэр аргаа ашиглан суудлын машин, автобусны загварыг бүтээх	Д,Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи I. 1 дүгээр ангийн сурах бичиг. УБ., 2017 он. хуудас 38-39,74 - Өнгийн цаас - Харандаа - Цаасны хайч - Цаасны цавуу																
1.2д. Цаасыг нугалах аргаар бүтээл хийх	- Цаас нугалж цэцэг, амьтны дүрс, хувцасны загвар яаж хийхийг сурах бичгийн 43, 58, 59, 70, 71-р хуудаснаас ажиглах - Цэцэг хийхдээ сурах бичгийн 58-р хуудасны 4.6 дугаар зурагт зааснаар ам дөрвөлжин өнгийн цаасыг 1-3 дарааллаар нугалах - Нугалсан цэцэгтээ иш, навч хийж хооронд нь цаасны цавуугаар наах - Цэцэг хийсэн энэ аргачлалаар ам дөрвөлжин өнгийн цаасыг сурах бичгийн 70-р хуудсанд заасан 1-3 дарааллаар нугалж, загас, хулгана, ямааны загварыг бүтээх - Эсгий балаар чимэглэх	Д. Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи I.1 дүгээр ангийн сурах бичиг. УБ., 2017 он. хуудас 58,59,70,71 - Өнгийн цаас - Харандаа - Цаасны хайч - Цаасны цавуу - Эсгий бал																

1.2е. Навч өрж наах аргаар амьтны дүрс бүтээх	- Сурах бичгийн 12, 13-р хуудаснаас хатсан навчаар загас, туулай, цэцэг яаж хийснийг ярилцах - Загас хийхдээ эхлээд 3 ш навч сонгож авах - Сонгосон навчаа зохиомжлон байрлуулж, хооронд нь цаасны цавуугаар нааж холбох - Загасны нүдийг цагаан өнгийн цаасаар хийж эсгий балаар зурах - Дээрх аргачлалаар навчаа зохиомжлон байрлуулж, сурах бичгийн 13-р хуудсанд заасан үйл ажиллагааны дарааллаар нааснаар туулай, цэцэгний загвар бүтээх - Навчаар хийсэн загасыг цэнхэр өнгийн цаасан дээр байрлуулж нааснаар аквариум доторх загасыг санагдуулах Сурах бичгийн 12-р хуудасны 1.24 дүгээр зургийг ажиглаж хийх - Туулайг ногоон өнгийн цаасан дээр байрлуулж, эргэн тойрныг нь цэцэг, модлог ургамлын дүрсээр чимэглэж сурах бичгийн 13-р хуудасны зургийг ажиглаж наах <i>/Хийх дадлага ажлын тоогоор багшаас сурагчдыг баг болгон ажиллуулж болно. Жишээ нь нэг хэсэг сурагчид загас, нөгөө хэсэг сурагчид туулай, бусад нь цэцэг хийх жишээтэй. Ургамлын навчны өнгө яагаад өөрчлөгдөж байгаа, навчаа яаж зохиомжлон байрлуулж наасан тухай сурагчдаар яриулах ажлыг багшаас зохион байгуулна/.</i>	Д,Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи I. 1 дүгээр ангийн сурах бичиг. УБ., 2017 он. хуудас 12,13 - Улаан, цагаан, цэнхэр, ногоон өнгийн цаас - Харандаа - Цаасны хайч - Цаасны цавуу - Эсгий бал
1.2ж. Баримлын шавартай ажиллах хэрэглэгдэхүүнийг таньж, зориулалтыг тодорхойлох	<i>/Багшаас баримлыг барьсан хойноо хатуурдаггүй /а/, хатуурдаг /б-полимер/ хоёр төрлийн баримлын шавар байдаг тухай мэдсэн байна. Шаардлагатай гэж үзвэл ийм хоёр төрлийн баримлын шавар байдаг тухай танилцуулж болох юм. Баримлын шавраар баримал барихад хэрчих, хэлбэр гаргах, чимэглэхэд зориулсан хэрэгслийг /в/ ашигладаг. 1-р ангийн 6 настай хүүхдийн хувьд баримлын шаварт өөрт нь ирдэг хэрэгслийг ашиглана/.</i>  а  б  в - Сурагчид төрөл бүрийн баримлын шавар, тэдгээртэй ажиллах хэрэгсэлтэй танилцаж, зориулалтаар нь сонгох	- Баримлын шавар - Баримлын шавар хэрчихэд зориулсан хутга - Нойтон алчуур, Баримлын шаврын доор тавих хулдаас

1.2з. Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх аргаар хагас товгор дүрс бүтээх	- Баримлын шаврыг хавтгайлах элдүүртэй /а/ танилцах Хэрэв зориулалтын элдүүр байхгүй бол шилэн лонх ашиглаж болно. <i>Хагас товгор дүрсийг баримлын шавраар хэвлэхэд</i> хоёр төрлийн арга байдаг. Үүнд: - Баримлын шавраа тавиад элдүүрээр элдэж хавтгайлах. Хавтгайлсан баримлын шавар дээрээ хэвээ байрлуулж дарж хэвлэх - Хэвэндээ баримлын шавраа гараар шахаж дүүргэж /б/ хэвлэн турших   а б	Д. Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи I. 1 дүгээр ангийн сурах бичиг. УБ., 2017 он. хуудас 20,21 - Нойтон алчуур - Баримлын шавар - Баримлын шаврын доор тавих хулдаас - Элдүүр - Хэв
1.2и. Баримлын шаврыг цувих, хэрчих, бөөрөнхийлэх, холбох, мушгих аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний загвар хийх	- Сурах бичгийн 21-р хуудасны 1.51 дүгээр зураг 6 настай М.Төрболдын “Үлэг гүрвэл” баримлыг ажиглах. - Баримлын шаврыг хоёр гарын алганы хооронд цувих, бөөрөнхийлөх, савх модны тусламжтайгаар хавтгайлах аргыг багшаас биетээр үзүүлж, сурагчид даган дуурайж хийнэ. Сурах бичгийн 20-р хуудасны 1.49 дүгээр зурагт үзүүлсэн аргачлалыг ашиглах - Цувих, хавтгайлах, бөөрөнхийлөх аргаар бэлтгэсэн баримлын шавраар сурах бичгийн 20-р хуудасны 1.50 дугаар зурагт үзүүлсэн жимс, ногооны баримлыг дуурайж барих              	

ХОЁРДУГААР АНГИ




2.1 ДҮРСЛЭХ УРЛАГ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.1а. Үндсэн өнгийг хольж, үүсмэл өнгүүдийг үүсгэх замаар үндсэн болон үүсмэл өнгийн ялгааг таньж тодорхойлох	<i>/Багш, сурагчдын тоогоор өнгийн хүрдний хар зурган, ватум цаасан хэв бэлтгэн тарааж өгнө/.</i> - Үндсэн өнгийг хооронд нь хольж, найруулан өнгийн хүрдэнд байршуулах туршилтыг сурагчид сурах бичгийн аргачлалын дагуу гүйцэтгэх - Будгийн нийлүүрт үндсэн 3 өнгийг найруулан түүнээс хурууны өндгөнд түрхээд үүсмэл өнгө гарган туршиж үзэх - Өнгийг таньж, ялгах тоглоомыг сурах бичигт байгаа зааврын дагуу тоглуулан шалгах - Туршилт хийж, будсан өнгийн хүрдийг, зургийн дэвтэрт наах	Гуаш, усан будаг, бийр, будгийн нийлүүр, устай сав, нойтон сальфетик, нэг удаагийн аяга, өнгө мэдрэх тоглоом, сурах бичиг, зургийн дэвтэр, цаасны цувуу, хүрдний ТӨМ
2.1б. Үндсэн болон үүсмэл өнгийг зураг дүрслэлдээ ашиглах	<i>/Багш өмнөх туршилтуудыг сэргэн сануулж ярилцана/</i> - Үндсэн ба үүсмэл өнгийг хольж өнгө үүсгэх турших <i>/Багш сурагч бүрийн тоогоор дасгалын хуудсуудыг тараан өгч ажиллуулах/</i> - Дасгалын хуудас дээр сурагч бүр өнгө хольж будах. - шар+улаан+дахин нэг дусал улаан+дахин нэг дусал улаан - улаан+нэг дусал хөх+ дахин нэг дусал хөх+ дахин нэг дусал хөх -шар+ нэг дусал хөх+ нэг дусал хөх өнгийг нэмж хольж найруулахад өнгө хэрхэн хувирч байгааг турших, ажиглах, харьцуулан ярилцах - Үүссэн өнгүүдийг ашиглан хүнсний ногооноос сонгон зураг зурна.	Дасгалын хуудас, хүнсний ногооны фото зураг ТӨМ, гуаш,усан будаг, бийр,будгийн нийлүүр, устай сав, нойтон сальфетик, зургийн дэвтэр, харандаа, баллуур
2.1в. Хуруугаар дардаслах аргаар толбо үүсгэн өөрийн бодол төсөөллөөр баяжуулан зурах	<i>/Багш сурагчдын тоогоор цагаан өнгөтэй слайд бэлтгэсэн байна/.</i> - Сурагчид сурах бичигт байгаа аргачлалыг 2 минут уншуулж, зургийг ажиглуулаад, номыг хаалгаж ярилцах - Сурагчид слайдан дээр, гуаш, усан будаг, эсгий бал, соруул ашиглан туршилт хийх. <i>/Багш туршилт хийх явцад аюулгүй ажиллагааг сануулах/</i> - Төрсөн сэтгэгдлээ багш, найз, нөхөдтөйгөө хуваалцах - Зургийн дэвтэрт тэнгэр, газрыг өнгийн цаасаар наалгаж, зуны амралтаараа харсан цэцэг, эрвээхий, соно, цох, хорхойноос сонгон туршилтын аргаар чөлөөт бүтээл, толболон урлаж, чимэглэх	Слайд-ТӨМ, сурах бичиг гуаш, усан будаг, бийр, будгийн нийлүүр, устай сав, нойтон сальфетик, зургийн дэвтэр, харандаа, баллуур, соруул, өнгийн цаас, хайч, цавуу

2.1г. Ургамал, амьтан дүрслэхдээ махир зураасыг хэрэглэх	<i>/Багш самбарт А1 нимгэн цагаан цаасыг соронзоор тогтоож, эсрэг өнгөтэй утсаар (0-ийн утас) шулуун, тахир, махир зураас үүсгэн, скочоор тогтооно./</i> - Сурагчид ямар зураас болохыг нэрлэх, ялгах, холбогдолтой амьтан, эд юмсын зургийг зөв байршуулах, дасгалыг гүйцэтгэх. - Сурагчид багшийн тарааж өгсөн слайдан дээр эсрэг өнгийн эсгий балаар махир зураасыг босоо, ташуу, хөндлөн чиглэлээр татаж, гар зүгшрүүлэх дасгал хийж багшдаа өргөн харуулах, ярилцах - Зургийн дэвтэртээ өөрийн сайн мэддэг ургамал, амьтныг махир зураасаар зурна.	А1 нимгэн цаас, соронз, слайд, 00-н утас, скоч, амьтан, эд юмсын зураг, эсгий бал, зургийн дэвтэр, харандаа, баллуур, сурах бичиг
2.1д. Эд юмсыг зурахдаа үндсэн 5 дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөх аргыг ашиглах	<i>/Сурагчдыг баг болгон хувааж, баг бүрд А3 цаасан дээр өөр, өөр эд юмсыг зургийн дагуу дүрсээр эвлүүлж, самбарт байрлуулан ярилцах/</i> - Сурагчид дээрх эвлүүлгээс санаа авч чөлөөт юмсыг багшийн тарааж өгсөн дүрсүүдийг зургийн дэвтэртээ зохиомжлон тавьж, тойруулан зурж, шинэ хэлбэр үүсгэн өнгөөр жигд таглан будах, бүтээлээ өргөн харуулах, дүгнэж ярилцах	Хүүхдийн бүтээл, А3 цаас, скоч, Эвлүүлдэг дүрсэн ТӨМ, хэв дүрсүүд, зургийн дэвтэр, харандаа, баллуур Усан будаг, гуаш, бийр, будгийн нийлүүр, устай сав
2.1е. Уншсан зүйлийнхээ агуулгаар зурсан зургаас гол ба туслах дүрийн ялгааг тайлбарлах	- Сурах бичгээс зохиолч Ж.Дашдондогийн “Цэнхэр салхи”, “Үхэр тэрэг” шүлгийг харааны уншлагаар унших - Уншсан эх, шүлгийн утга санааг илэрхийлсэн зураг зурах - Эхийн үйл явдлыг харуулсан зураг зурж жижиг ном хийх - Үйл явдлын дарааллыг төлөвлөн харандаагаар дүрслэн зурах - Зурсан дүрсээ усан будаг, гуашаар будах - Бүх дүрсээ хүрээлэн тодруулах. - Бүтээлээ солилцож, бие биенээсээ сайжруулах санал гаргах	Усан будаг, гуаш, бийр, будгийн нийлүүр, устай сав, зургийн дэвтэр, харандаа, баллуур Нойтон алчуур, Сэдэлжүүлэх зурагт үзүүлэн
2.1ж. Давхцуулан зурах аргаар юмсын наана, цаана хол, ойр байршлыг дүрслэн харуулах	<i>/Наана, цаана байршилтай 2 зүйлийг давхцуулан байрлуулан зурсан зурагт үзүүлэн дээр ярилцаж болно./</i> - Зурах 2 зүйлээ багштайгаа ярилцаж сонгох - Зурахаар сонгосон 2 зүйлийг давхцуулан дүрслэх - Наана, цаана байгаа ялган зурж будах - Орчин бүрдүүлэн баяжуулан зурах - Зурсан юмсын наана, цаана хол, ойр байршлыг тайлбарлах, багштайгаа хамтран ярилцах	Гуаш, усан будаг, бийр, будгийн нийлүүр, устай сав, нойтон сальфетик, зургийн дэвтэр, харандаа, баллуур

2.1з. Хоёр өнгөөр дагнааслан будах аргаар цэцэг, навчин хээг дүрслэх	<i>/Багш самбарт үндсэн ба үүсмэл, ойролцоо өнгийн өнгийн цаасыг холж, соронзоор байрлуулна/.</i> - Сурагчаар ойролцоо хоёр өнгөөр нь ялган байрлуулуулах - Хээ угалзын дагнаастай харьцуулан ярилцах - Самбарыг дөрөв хуваан шугам татаад будах зурвасыг хэвтээ, босоо шулуун, хэвтээ, босоо муруй чиглэлээр зурааслан зурах, дагнааслах - Хоёр зурвасыг дагнааслан будахдаа эхлээд хүнд (ханасан) өнгөөр эхний зурвасыг будаж хатаах, дараа нь хоёр дахь зурвасыг хөнгөн өнгөөр будах <i>/Дагнааслахдаа зурвасын зураасыг давуулахгүй, дутаахгүй жигд будахад чиглүүлнэ/.</i> - Сурагчид дээрх дасгалыг гүйцэтгэсний дараа, цэцэг, навчин хээний хэв дүрсийг ашиглан дагнааслан будах дадлагыг бие даан гүйцэтгэнэ.	Өнгийн цаас, соронз, гуаш, хавтгай үстэй өргөн бийр, будаг холигч, усны сав, хээ угалзын өнгөт үзүүлэн, зургийн дэвтэр, харандаа, баллуур, сурах бичиг
2.1и. Чулуун дээр зураас арилгагч (штрих), шохойн ба лааны тосон харандаагаар зураг зурах аргыг турших	- Багш дэлгэцээр эртний хадны сүг зураг харуулан юуг, юугаар дүрсэлсэн болохыг таамаглал дэвшүүлж, ярилцах - Зураг зурахад тохиромжтой мөлгөр хавтгай чулууг угааж бэлтгэх - Чулуун дээр зураас арилгагч (штрих) болон лааны шохойн харандааг ашиглан зураг зурах - Сурах бичгээс зурах дараалалтай танилцан, ажиглаад өөрт таалагдсан зургийг чулуун дээр зураад, үзэсгэлэн гаргаж, тайлбарлан ярилцах	Хадны сүг зургийн Фото-ТӨМ, угаасан чулуу, зураас арилгагч (штрих), шохойн ба лааны тосон харандаа, цавуу, нойтон алчуур гэх мэт.

2.2 ТЕХНОЛОГИ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.2а. Үндсэн дүрсээр нийлмэл дүрс бүтээж, харьцуулан тайлбарлах	- Өмнөх ангид өнгийн цаасаар ам дөрвөлжин, дугуй, гурвалжин, зууван дугуй, гонзгой дөрвөлжин дүрсийг зураас дагуулан хайчилж цэцэг, гэр, байшингийн дүрсийг байгалийн зураг дээр хэрхэн зохиомжлон нааснаа бататган бусадтай ярилцах - Өнгийн цаасаар хийсэн ам дөрвөлжин, гонзгой дөрвөлжин дүрсийг хоёр оройг нь дайруулан татсан зураасаар, гурвалжин дүрсийн оройг суурьтай нь холбосон зураасаар, дугуй ба зууван дугуй дүрсийг таллан хуваасан зураасаар хайчлах      а б в г д	-Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи II. 2 дугаар ангийн сурах бичиг. УБ., 2015 он. Хуудас 28,29 - Үндсэн дүрс, нийлмэл дүрс - Цаасны хайч - Цаасны цавуу - Өнгийн цаас - Бэлэн зураг - БСШУЯ, JiCA, МУБИС,Токиогийн Технологийн Сургууль. “Бага боловсролын чанарыг ахиулахад мэдээлэл харилцааны технологийг оновчтой ашиглах нь” төсөл.

	- 2.14 дүгээр зурагт үзүүлсэн аргаар багшаас бэлэн зураг өгч түүн дээр зарим дүрсэн загвараа байрлуулж наах - Дүрсэн загварынхаа утгыг тайлбарлах <i>Дүрсийг бүтээхдээ:</i> • <i>Нугалж хайчлах аргаар</i> • <i>Хэв тавьж зурах, зураасны дагуу хайчлах аргаар</i> • <i>Хэмжээ тавихад зориулсан шугам, гортигны тусламжтайгаар байгуулна.</i> <i>/Нэмэлт мэдээлэл: Үндсэн дүрсийг таллан хуваахад үүссэн дүрсийг нийлмэл дүрс гэнэ. Багшаас нээлттэй Scratch, TuxPaint программ ашиглах. Энэ программ нь бага насны хүүхдэд зориулсан хялбар интерфэйс, хөгжилтэй дууны эффект, сонирхол татахаар зурах хэрэгсэлтэй, бага ангийн дүрслэх урлаг, технологийн хичээлд ашиглах боломжтой. http://www.tuxpaint.org/download/ хаягаар татаж авч болно/.</i>	Бага ангийн багшийн гарын авлага. УБ.,2015 он. Х82-122 Технологийн бага боловсрол ба мэдээлэл харилцааны технологи /сургууль, багш нарын боловсруулсан сургалтын материал/
2.2б. Ам дөрвөлжин цаасан нугалаагаар амьтны дүрс бүтээх	- Сурах бичгийн 24, 25, 32, 33-р хуудасны цаас нугалж тахиа, гөлөг, шувууны дүрс бүтээх дадлага ажлыг ажиглаж, эхлээд хамгийн хялбар нугалаатай дадлага ажлыг сонгоно. Үүнд: - 25-р хуудасны цаас нугалж бүтээсэн гөлөгний зургийг ажиглах - 2.5 дугаар зургын аргачлалаар гөлөгний толгойг, 2.6 дугаар зургийн аргачлалаар гөлөгний биеийг хийх - Төгсгөлд нь гөлөгний толгой ба биеийг хооронд нь 2.7 дугаар зураг харж холбож цаасны цавуугаар наах - Сурах бичгийн 32-р хуудасны 2.22-р зургийн 3, 4 түүнчлэн 2.23 дугаар зургийн 4, 5-ийг ажиглахад шувууны толгойг 2 өөр хэлбэрээр нугалсныг, бусад нугалах аргачлал нь энэ 2 хувилбарт адилхан байгааг ажиглах - Хос хосоор суугаад нэг нь 2.22 дугаар зурагт заасан аргачлалаар, нөгөө нь 2-23 дугаар зурагт заасан аргачлалаар шувууны дүрсийг нугалах - Төгсгөлд нь бүтээсэн шувууны дүрсээ тогтоох суурийг баримлын шавар, бөглөөгөөр хийж хооронд балны пүршээр холбох	-Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи II. 2 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Хуудас 24,25,32,33 - Цаасны хайч - Цаасны цавуу - Өнгийн цаас - Үйсэн бөглөө - Балны пүрш - Баримлын шавар
2.2в. Цаасыг хуйлах, тэнийлгэх аргаар бэлэг дурсгалын бүтээл хийх	- Сурах бичгийн 16-р хуудасны харандаагаар гол хийж, цаасыг шулуун чиглэлд, булангаас хуйлах, түүнийгээ ширээний ирмэгт татаж тэнийлгэх, хайчлах, наах дасгал хийх - Сурах бичгийн 12-р хуудасны зааны дүрс, могойн дүрс, 17-р хуудасны зургийн жааз хийх дадлага ажлаас сурагчид сонгож хийх	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи II.2 дугаар ангийн сурах бичиг. УБ. 2015 он. Хуудас 12,16,17 - Цаасны хайч - Цаасны цавуу - Өнгийн цаас

2.2г. Үндсэн ба нийлмэл дүрсийг эвлүүлж, наах аргаар техникийн загвар бүтээх	- Үндсэн ба таллан хуваасан дүрсээр сурах бичгийн 2.11, 2.12 дугаар зурагт машин ба байшин, 2.13 дугаар зурагт хүний дүрсэн загвар ямар нийлмэл дүрсүүдийг яаж зохиомжлон бүтээснийг ажиглах <i>/Багшаас 2.11 дүгээр зурагт үзүүлсэн машин ба байшингийн, 2.12 дугаар зурагт үзүүлсэн ачааны машины дүрсэн загварт таллан хуваасан гурвалжин дүрсүүд орсон байгааг сурагчдад тайлбарлана. 1-р ангидаа сурагчид дүрсэн загварт хэдэн үндсэн дүрс орсон түүнийг тоолж, цифрээр бичиж сурсан учир хуудас 28, 29-ийн дүрсэн загваруудад хэдэн төрлийн ямар дүрс байгааг таньж, тоолж чадах болно/.</i> - Өнгийн цаасан дээр зурсан дүрсүүдийг зураасны дагуу хайчилж бэлтгэх - Хайчилж бэлтгэсэн нийлмэл дүрсүүдээр сурах бичгийн 28-29-р хуудасны дүрсэн загвараас сонгож хийх - Эхлээд загварт тохирох дүрсээ сонгох - Сонгосон дүрсээ зохиомжлон байрлуулж наах	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи II. 2 дугаар ангийн сурах бичиг. УБ. 2015 он. Хуудас 13, 28, 29 - Цаасны хайч - Цаасны цавуу - Өнгийн цаас - Харандаа, баллуур
2.2д. Олон дүрс ашиглаж, эвлүүлдэг тоглоом зохион бүтээх	- Сурах бичгийн 72-р хуудасны “Долоодой” тоглоомын дүрсийг ажиглаж, урьдчилан хайчилж бэлтгэсэн дүрсүүдээс энэ тоглоомд орох дүрсүүдийг ялгаж авах - Ялгаж авсан дүрсүүдээр туулай, үнэг, муур гэх мэт амьтдын дүрсийг сурах бичгийн 4.30, 4.31, 4.32, 4.33-р зургийн аргачлалаар бүтээх - Сурах бичгийн 73-р хуудасны 4.34 дүгээр зургийн дагуу бүтээсэн амьтдын дүрстэй холбоотой орчин үүсгэж зураг зурах <i>/Энэхүү суралцахуйн зорилттой холбоотой дараах түлхүүр үг ашиглаж мэдээллийг хайх. Жишээ нь: “Долоодой”, “Эв долоо”, “Танграмм” гэдэг түлхүүр үгээр интернетийн мэдээллийг хайхад эвлүүлдэг тоглоомын олон хувилбартай танилцах болно/.</i>	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи II. 2 дугаар ангийн сурах бичиг. УБ.2015 он. Хуудас 72,73 - Цаасны хайч - Цаасны цавуу - Өнгийн харандаан будаг
2.2е. Ургамал амьтны дүрс бүтээхэд баримлын шаврыг цаасан дээр нялж наах аргыг ашиглах	- Баримлын шавраа цаасан дээр нялж наах аргаар зүлэг бэлтгэх - Цэцгийг баримлын шавраар товгор хийж, бэлтгэсэн зүлэг дээрээ наах - Сурах бичгийн 40-р хуудасны 3.4 дүгээр зэргийн аргачлалаар эрвээхий, цох хорхой хийж, цэцгийн орчин тойрныг үүсгэх	Д.Цэдэн-Иш нар, Дүрслэх урлаг, технологи II. 2 дугаар ангийн сурах бичиг. УБ.2015 он. Хуудас 40 - Цаас - Зургийн дэвтрийн цаас - Баримлын шавар - Нойтон алчуур - Хулдаас

2.2ж. Баримлын шавар, савх модыг холбох аргаар мал, амьтны загвар хийх, бүрдэл хэсгийг нэрлэх	- Хүн, амьтан нь толгой, их бие, чих, нүд, хөлтэй, энэ ойлголтоо сурах бичгийн 41-р хуудасны тугал, 45-р хуудасны үнэг, аалзны жишээгээр бататгаж ярилцах - Хүн, амьтны толгой, их бие, чих, нүд, хөл болон юмсын бүрдэл хэсгийг савх модоор холбож баримал барих - Сурах бичгийн 45-р хуудасны 7, 8 настай хүүхдүүдийн барьсан баримлыг ажиглаж, яаж барьсан аргачлалаар өөр хоорондоо ярилцах - Төөлүүр хорхой, мөөг, зараа, аалз зэрэг амьтдын баримлыг барих - Амьтны загварын бүрдэл хэсгийг нэрлэх	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи II.2 дугаар ангийн сурах бичиг. УБ. 2015 он. Хуудас 41, 44, 45,48, 49 - Цаас - Зургийн дэвтрийн цаас - Баримлын шавар - Нойтон алчуур - Хулдаас
2.2з. Өвс ургамал навчаар 2 хэмжээст бүтээл хийх	- Мөчир, навч, ургамлын иш, өвс түүж бэлтгэх. - Бэлтгэсэн зүйлээ цэвэрлэх - Навчийг туузан наалтуураар /скоч/ битүү наах - Сурах бичгийн 8-р хуудасны 1.8 дугаар зурагт “Аалз”, 1.9 дүгээр зурагт “Тогоруу”, 9-р хуудасны 1.10 дугаар зурагт “Хулгана”-ыг байгалийн ямар материал ашиглаж, яаж хийсэн тухай ярилцах - 3 баг болж сонирхлоороо нэг баг нь аалз, нөгөө багнь тогоруу, үлдсэн хэсэг нь хулганы загварыг хийх - Хийж бүтээсэн зүйлээрээ ангидаа үзэсгэлэн зохион байгуулж, хэсэг бүр хийсэн бүтээлээ танилцуулах	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи II. 2 дугаар ангийн сурах бичиг. УБ.2015 он. Хуудас 8, 9 - Зургийн дэвтрийн цаас - Мөчир, навч, ургамлын иш - Баримлын шавар - Цаасны цавуу, хайч - Цаасны хайч - Скоч
2.2и. Өнгө өнгийн чулууг баримлын шавраар холбох аргаар амьтны баримал хийх	- Өнгө өнгийн янз бүрийн хэлбэр, хэмжээтэй чулуу цуглуулж угааж бэлтгэх - “Эрвээхий”, “Нохой”-ны загварыг чулууг өөр хооронд нь баримлын шавраар хэрхэн нааж хийсэн тухай сурах бичгийн 8-р хуудаснаас танилцах - Цуглуулсан чулууны өнгө, хэлбэрээс хамаарч юу хийхээ өөр хоорондоо ярилцаж хийх зүйлээ сонгох <i>/Багшаас байгалийн өвөрмөц тогтоцтой чулуу байдаг тухай зурган мэдээлэл үзүүлж тайлбарлах зэргээр сурагчдын сониуч зан сонирхлыг төрүүлнэ/.</i> - Сурах бичгийн 65-р хуудасны 4-18 дугаарт үзүүлсэн “Чулуун баримал”-аас санаа авч өөрсдийн бодол төсөөллөөр баримал барих	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи II. 2 дугаар ангийн сурах бичиг. УБ.2015 он. Хуудас 64,65 - Өнгө өнгийн чулуу - Баримлын шавар - Нэг удаа хэрэглэх аяга - Өвөрмөц тогтоцтой чулууг үзүүлсэн зурган мэдээлэл

2.2к. Номын хавчуурга хийхэд төрөл бүрийн материал ашиглах	- Бичгийн хавчаар, даавуун тууз, сувс, цаасны хайч, цаасны цавуу бэлтгэх - Гонзгой дөрвөлжин цаас, бичгийн хавчаар ашиглаж хийсэн номын 2 төрлийн хавчаарын зургийн тайлбарыг сурах бичгийн 56, 57-р хуудаснаас уншиж, яаж хийсэн аргыг ярилцах - Хоёр хоёроороо хос болон сууж, нэг нь сурах бичгийн 56-р хуудасны 4.7 дугаар зургийн үйл ажиллагааны 1-5 дарааллаар, нөгөө нь сурах бичгийн 57-р хуудасны 1-4 дарааллаар номын хавчуурга хийх	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи II. 2 дугаар ангийн сурах бичиг. УБ. 2015 он. Хуудас 56, 57 - Бичгийн хавчаар - Даавуун тууз - Сувс - Цаасны хайч - Цаасны цавуу
2.2л. Шувууны тэжээл бэлтгэхэд цаасан хайрцаг ашиглах	- Төрөл бүрийн цаасан хайрцаг цуглуулах - Гэр ахуйн нөхцөлд бэлтгэсэн шувууны тэжээлийг цаасан хайрцаганд хийж, хоёр талд нь нарийн уяа бүч тогтоох - Хайрцгийн нүүрэн талыг шувуу суухаар, идэш тэжээл унахааргүй оновчтой хувилбараар хагалах. - Хийж бүтээсэн зүйлээ сургууль гэр орны орчны модонд өлгөх <i>/Багшийн анхаарах зүйл: Багшаас интернетийн хайлтын системд шувуудтай холбоотой түлхүүр үг ашиглан ороход шувуудын амьдрал орчинтой холбоотой видео бичлэгийг сурагчдад үзүүлэх боломжтой/.</i>	- Цаасан хайрцаг - Цаасны хайч - Цаасны хутга - Нарийн уяа бүч - Цаасны цавуу

ГУРАВДУГААР АНГИ


3.1. ДҮРСЛЭХ УРЛАГ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.1а. Өнгийн хүрдийг ажиглаж дулаан, хүйтэн өнгийг ялгааг таньж тодорхойлох	- Сурах бичигт байгаа өнгийн хүрд, өнгийн тухай мэдээллийг унших, зурган мэдээллийг ажиглан дулаан, хүйтэн өнгүүдийг тодорхойлох - Сурах бичгийн даалгаврын алхам 1, 2-г уншиж өнгийн туузан цаасыг зургийн дагуу зааглан байрлуулах туршилт хийх, сэтгэгдлээ илэрхийлэн ярилцах <i>/Багш дулаан, хүйтэн өнгөтэй цаасыг хольж, самбарт, соронзоор байрлуулан, нэг сурагчийг нэр цохон гаргаж, дулаан, хүйтэн өнгөөр зааглан ялгуулна./</i> - Самбарт байршуулсан өнгийн цаасыг дулаан, хүйтэн өнгөөр нь ялгах. - Сурагчид өөрт байгаа харандаан будаг, өнгийн эсгий балыг дээрх аргын дагуу гүйцэтгэн, дүгнэж, ярилцах.	Сурах бичиг, өнгийн цаас, соронз, харандаан Будаг, эсгий бал

3.1б. Дулаан, хүйтэн өнгийг байгалийн зураг дүрслэлд ашиглах	- Сурагчид багийн зохион байгуулалт орох. <i>/Багш багуудад дулаан, хүйтэн өнгөөр зурсан байгалийн фото зургууд тарааж, ялгах даалгавар өгч болно/.</i> - Сурагчид өөрт таалагдсан байгалийн агшинг, тохирох өнгөөр илэрхийлэн зурах <i>/Багш энэ агшинд байгалийн дуу, чимгээний аялгууг намуухан сонсгох./</i> - Багууд үзэсгэлэн гаргаж, харьцуулан ярилцаж, дүгнэлт гаргах	Зургийн дэвтэр, гуаш, усан будаг, бийр, нийлүүр, устай сав, нойтон цаас, байгалийн агшинг харуулсан, фото зургийн ТӨМ, хөгжим
3.1в. Санамсаргүйгээр толбо үүсгэх аргыг зураг дүрслэлдээ ашиглах	<i>/Багш бид 2-р ангидаа ямар аргаар толболон бүтээл хийж байсан эсэхийг сэргээн сануулж ярилцана/.</i> - Сурагчид сурах бичгийн аргачлалыг ажиглаад юуг, ямар аргаар толболон бүтээхээ сонгох - Толболон дүрс үүсгэх аргаар амьтан, ургамал, эд зүйлсийг дүрслэн зурах - Толбоны хэлбэр нь ихэвчлэн дугуй ба зууван дугуй байна. - Нэмэлт цэг, толбо, зураас ашиглан баяжуулж дүрслэх	Зургийн дэвтэр, гуаш, усан будаг, бийр, нийлүүр, устай сав, нойтон цаас, толбологч, эсгий бал
3.1г. Юмсын хатуу, зөөлөн, тогтвортой, хөдөлгөөнтэй зэрэг шинж чанарыг зураасны төрлүүдээр илэрхийлэх	<i>/Зураасны шинж чанарыг таниулахын тулд багш самбарт зураасны нэр, төрөл, түүнд хамааралтай, фото зургуудыг байрлуулан, онцлог, ялгааг ажиглуулж, зөв харгалзуулах дасгалыг нэг сурагчаар гүйцэтгүүлэн чиглүүлнэ/.</i> - Сурах бичгээс зураасаар юуг илэрхийлж болох вэ? мэдээллийг 2 минут уншиж, номоо хаан ярилцах - Будгаа өтгөвтөр найруулаад, бэлтгэсэн хатуу цаасны ирмэгийг будаж багшийн тарааж өгсөн слайд дээр дардас гарган зураасын төрлийг дүрсэлж, турших - Зураасны төрлүүдийг ашиглан "Хөдөө нутаг" сэдвээр дүрслэн зурж, харьцуулан ярилцах	1-2 см-ийн өргөн, 7-10см урттай хатуу цаас, гуаш, усан будаг, бийр, дэвтэр, хайч, будгийн нийлүүр, нойтон алчуур, тараах материал, Үзүүлэн, фото зургууд, сурах бичиг
3.1д. Үндсэн дүрсүүдийг дардаслан олшруулах аргаар зохиомжийн талаарх ойлголтоо харуулах	- Сурагчдын тоглох дуртай олон өнгө хэлбэртэй дардаслан чимэглэдэг зүйлсээр нь сэдэлжүүлнэ. <i>/Багш хатуу кардон цаасаар хийсэн янз бүрийн хэлбэртэй дүрсэн дардсуудыг багуудад тарааж өгнө/.</i> - Сурах бичгээс дардаслах аргыг ажиглуулан асууж, ярилцах - Дүрсэн дардсаа өтгөвтөр будгаар будаж, слайдан дээр дардаслан давтамж үүсгэн турших - Багууд А2 ватум цаасан дээр туршилтаас төрсөн сэдвийн дагуу харилцан ярилцаад чөлөөт зохиомж дардаслан чимэглэх - Хамтын бүтээлээ тайлбарлах - Бусад багууд саналаа хуваалцаж дүгнэн ярилцах	Хатуу цаасан дардасны ТӨМ, слайд, дардас гаргах зүйлсүүд, ватум, усан будаг, гуаш, бийр, будгийн нийлүүр, устай сав, хайч, цавуу

3.1е. Хүүхдийн зураг, бүтээлүүдээс төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлэх	- Хүүхдийн бүтээлүүдээс, самбарт байрлуулж, ямар сэдэвтэй, гол ба туслах дүрийн байршил, ямар цаг, үе, агшинг илэрхийлсэн болохыг харьцуулан ажиглуулж, ярилцах <i>/Сурах бичигт байгаа хүүхдийн бүтээлийг ажиглуулна/.</i> - Бүтээлээс төрсөн сэтгэгдлээ слайд дээр эсгий балаар 3 минут орчим зураад багш болон найзууддаа харуулан, санаа бодлоо хуваалцаад, зургийн дэвтэртээ баяжуулан зурах <i>/Багш намуухан ая сонсгоно./</i>	А3-н хүүхдийн бүтээлүүд, соронз, Слайд-ТӨМ, өнгийн эсгий бал, зургийн дэвтэр, харандаа, баллуур
3.1ж. Бодит болон хийсвэр зургийг харьцуулан орон зай, илэрхийллийн ялгааг тайлбарлах	- Сурах бичгээс Зураач Б.Насанцэнгэл "Зураач охин", Ч.Цогбаяр "Хурагчин охин", сурагч Д.Ундрам "Үнсгэлжин", Голяк Яна "Беларус охин" бүтээлийг харьцуулан ажиглуулах, ялгааг таамаглал дэвшүүлэн ярилцах <i>/Багш самбарт дээрх зураач болон хүүхдийн бүтээлийг А3 хэмжээн дээр томруулан өнгөтөөр канондаж, ярилцах асуулт, дарааллын хамт байрлуулах/</i>	А3-н бүтээлүүд, соронз, сурах бичиг, асуулт, дараалал
3.1з. Монголын зураачдын уран зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах	- Сурах бичигт байгаа зураачдын бүтээлтэй танилцахдаа асуулт, алхамын дагуу нэг бүтээлийг 3 минут уншуулаад 4-6 асуултанд 6 минут орчим хариулж бичих <i>/Багш сурагчдыг бүтээлээ уншиж ойлгон асуултанд хариулж бичсэний дараа дэвтэр, номыг хаалгаад дэлгэцээр зураачийн бүтээлийг тайлбаргүйгээр харуулж, дараах асуултын дагуу нэр цохон ярилцана./</i> - Уран бүтээлийн нэр, хэний бүтээл болох, хэдийд бүтээгдсэн, зургийн хавтгай дээр юу, юу дүрслэгдсэн, үйл явдлын, гол ба туслах дүрүүд хэрхэн холбогдсон. Амьдралын ямар ахуй харуулсан эсэх, ямар цаг хугацааг харуулсан эсэх, тухайн уран бүтээлд ямар өнгө зонхилсон болох эсэх талаар ярилцах	Сурах бичиг, зураачдын бүтээлийг цахим болон зургаар бэлтгэх Асуулт даалгаврыг бэлтгэх
3.1и. Гурван өнгөөр дагнааслан будах аргаар эвэр угалз дүрслэх	<i>/Багш самбарын нэг талд дулаан, хүйтэн өнгийн цаас байрлуулна. Нөгөө талд өнгийн ууслаар дүрслэгдсэн байгаль, хээ угалзын бүтээл байрлуулан өнгө хэрхэн будагдсаныг ажиглуулан ярилцаад, өнгийн цаасыг ойролцоо өнгөөр гурван зурвас үүсгэн байрлуулж, ялгуулна/.</i> - Сурагчид гуаш, усан будгаа өтгөвтөр найруулан, слайд дээр хавтгай үстэй бийрээр босоо, хэвтээ, чиглэлээр шулуун, муруй зураасыг зэрэгцүүлэн татаж, гараа зүгшрүүлэх - Зургийн дэвтрийг дөрөв хувааж, шугам татаад дээрх аргаар дагнааслах дадлага хийх	- Өнгийн цаас, - соронз, үзүүлэн, - слайд -ТӨМ, усан будаг, гуаш,бийр, будгийн нийлүүр, устай сав, зургийн - дэвтэр, шугам, - харандаа, баллуур

3.2 ТЕХНОЛОГИ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.2а. Үндсэн ба нийлмэл дүрсийн хэлбэрийг өөрчлөх аргаар амьтны загвар бүтээх	- Нэг удаагийн цаасан таваг, аягаар ямар амьтныг дууриалган хийж болох талаар ярилцах - Сурах бичгийн 36-р хуудасны “Тооройн баг”-ийг яаж хийсэн тухай ойлголттой болох - Үндсэн ба нийлмэл дүрсийн хэлбэрийг өөрчлөх аргаар амьтны чих, нүд, хамар, ам, толгой зэрэг эрхтнийг дуурайлган хийх. Жишээ нь, дугуй дүрсийг таллан хуваах аргаар амьтны толгойн загвар бүтээсэнтэй танилцах  <i>/Юмсын үндсэн шинж нь хэлбэр юм. Хүн, амьтан, ургамал, уул, чулуу, цас, мөс өөр өөрийн хэлбэртэй. Хүний үйл ажиллагаагаар бүтсэн юмсын хэлбэр нь геометр, биодизайн, этгээд шийдэлтэй, хавтгай, эзлэхүүнт, орон зайтай байдаг. Амьтан, ургамлыг дуурайлган хийсэн юмсын хэлбэрийг биодизайн шийдэлтэй гэдэг/.</i>	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х 36 - Нэг удаагийн цаасан таваг - Нэг удаагийн цаасан аяга - Өнгийн цаас - Зургийн хэрэгсэл - Цаасны цавуу - Цаасны хайч -
3.2б. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж загвар бүтээх	- Багшийг дагаж дараах үйл ажиллагаагаар цаас нугалж, завь хийх Үүнд: - Өнгийн цаасыг голоор нь давхарлаж нугалах - Битүү ам талаас нь хоёр үзүүрийг дотогш нь дарж нугалах - Задгай амыг хоёр тийш нь дарж нугалах - Задгай ам талаас 2 тийш нь татаж тэнийлгэх - Задгай ам талаас хошуулдаж хоёр тийш нь нугалах - Задгай амыг хоёр тийш нь татаж тэнийлгэх - Баруун ба зүүн гар талд үүссэн хөдөлгөөнтэй гурвалжин дүрсийг хоёр тийш нь татсанаар завь бий болгоно.  - Энэ нугалах аргыг ашиглан сонингийн цаасаар цаасан малгай хийх <i>/Интернетийн хайлтын системд “Оригами” гэсэн түлхүүр үг бичээд ороход сурагчдын хийх олон төрлийн дадлага ажилтай танилцах болно. “Оригами” гэдэг үг нь цаасан нугалбар урлаг гэсэн утгатай үг/.</i>	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х 28, 29

3.2в. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээх	Сурах бичгийн 30, 31-р хуудасны “Хамар угалз”-ыг дараах үйл ажиллагаагаар гүйцэтгэх Туршилт 1 - Урт туузан цаасыг нугалах - Нугалсан цаасан дээрээ хамар угалны хэсгийг зурах - Зурсан хэсгийг тойруулан хайчлах - Хайчилсан хамар угалзыг дэлгэхэд үргэлжилсэн ижил хэмжээ, хэлбэртэй дүрс бий болгох Туршилт 2 - Ам дөрвөлжин цаасыг хошуулдаж хэд дахин нугалах - Нугалсан цаасаа тойруулж хайчлах - Нугалсан ирмэгийг хэд хэдэн газар хэсэглэн хайчилж дэлгэхэд дугуй хэлбэртэй хээ үүсгэх - Дээрх хоёр туршилтын үр дүнд үүссэн чимэглэлийг юунд ашиглаж болохыг өөр хоорондоо ярилцах	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х 30, 31 - Цаасны цавуу - Цаасны хайч - Өнгийн цаас
3.2г. Хатуу цаасыг хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны загвар бүтээх	- Завсартаа зөөлөвчтэй хайрцгийн өнгөн картоныг хуулна. - Зөөлөвчийг туузалж хайчлах - Бүтээх амьтны бүрдэл хэсгүүдийг нэрлэх, бүрдэл хэсгүүдийн хэлбэрийг ажиглах - Бүрдэл хэсгүүдийн хэлбэрээр туузалж хайчилсан зөөлөвч картоныг хуйлж үзүүрийг наах, түүнийгээ хэлбэржүүлэх - Бүрдэл хэсгүүдийг хооронд нь зохиомжлон байрлуулж, цаасны цавуугаар холбож наах - Амьтны нүдийг будах эсвэл товч наах аргаар хийх - Дээрх аргачлалаар сурах бичгийн 24-р хуудасны 2.3 дугаар зураг “Дэгдээхий”, 25-р хуудасны 2.4 дүгээр зураг “Яст мэлхий”, “Эрвээхий”, “Загас”-ны загвараас сонгож хийх	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х 24, 25 - Хайрцгийн картон - Цаасны цавуу - Цаасны хайч - Товч
3.2д. Цаасыг нугалж хайчлах аргаар тэгш хэмийн тухай ойлголттоо тайлбарлах	- Хүн, мал амьтан, ургамал, хээ угалзны зураг харж тэгш хэмийн тухай энгийн ойлголттой болох. Жишээ нь хүн, мал амьтан аль аль нь хоёр нүдтэй, хоёр чихтэй гэх мэт. Энэ ойлголтыг олж авахад сурах бичгийн 30-р хуудасны 2.9 дүгээр зураг ашиглана. <i>/Энэ нь “Толин тэгш хэм”-ийн тухай ойлголт юм. Тэгш хэмийг толин, тэнхлэгийн, шурган гэж 3 ангилдаг. Юмсын нэг хагас нь нөгөө хагастайгаа тэнцвэрт байдалтай, өнгийн хувьд адилхан бол түүнийг толин тэгш хэм гэнэ/.</i> - Цаасыг нугалж, нугалсан цаасан дээрээ навчны нэг талыг дүрслэн зурж давхраар нь хайчлаад дэлгэхэд хоёр талдаа адилхан дүрс үүсгэх - Энэ дадлага ажлыг хийхдээ сурах бичгийн 19-р хуудасны аргачлалыг ажиглах - Сурах бичгийн 18-р хуудасны “Хонхон цэцэг”, 20-р хуудасны “Маалинга цэцэг”-ийг цаас нугалж хайчлах аргаар хэрхэн бүтээснийг уншиж ойлгох - Дээрх дадлага ажлуудаас сонгож хийх - “Хонхон цэцэг”, “Маалинга цэцэг”-ийн тухай сурах бичгийн мэдээллийг унших	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х 18,19,30,31 - Цаасны хайч - Цаасны цавуу - Харандаа, баллуур

3.2е. Цаасыг тэгш хэмээр нугалж, хайчлах аргаар техникийн загвар бүтээх	- Гонзгой дөрвөлжин цаасыг голоор нь хоёр тэнцүү нугалах - Нугалсан цаасны нэг тал дээр машин техникийн зургаа зурж давхарлан хайчлах - Давхарлаж хайчилсан дүрсээ дэлгэж, тухайн техникийн хаалга, цонх, дугуй болон бусад чимэглэлийг хийж наах - Давхарлаж хайчлах аргаар нисдэг тэрэг, машины загвар хийхэд сурах бичгийн 13-р хуудасны 1.9, 1.10 дугаар зурагт үзүүлсэн аргачлалыг ашиглах	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х 13 - Цаасны хайч - Өнгийн цаас, - Цаасны цавуу
3.2ж. Эд ангийг үлгэр ашиглан зурж хайчилж угсрах аргаар техникийн загвар бүтээх	Онгоцны загвар бүтээх дараалал: - Нимгэн картон дээр онгоцны их бие, далавчийг үлгэр хэвээр зурж, зураасны дагуу хайчлах - Далавчийг их биед нааж холбох - Бүтээсэн онгоцоо будаж чимэглэх - Савх модонд нарийн резин бэхэлж, онгоцоо нисгэж турших - Дээрх үйл ажиллагааны дарааллыг сурах бичгийн 56-р хуудасны 4.1 зургийн дагуу гүйцэтгэх	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х56 - Нимгэн картон - Цаасны хайч, - Цаасны цавуу - Савх мод - Нарийн резин - Онгоцны их бие, далавчны үлгэр хэв - Усан будаг - Д.Хөхөө. Технологийн бага боловсрол. Багшийн ном. УБ.,2006 он. Х87-99 Техникийн загвар.
3.2з. Байгалийн материалыг зохиомжлон наах, холбох аргаар бүтээл хийх	- Ургамлын хатсан навч, мөчир, үндэс, иш, боргоцой, ургамлын үр, цэцгийн хатаамал, самрын яс зэрэг байгалийн материал цуглуулах - Навчны хэлбэр, хэмжээ, өнгийг навчин наамалд тохируулан сонгох - Сонгосон навчаа амьтдын хэлбэр, өнгө зохицолд тохицуулан зохиомжлон байгалийн сэдэвт зураг дээр наах - Навчин наамлаар ямар ямар амьтны загвар хийж болохыг сурах бичгийн 8-р хуудасны 1.4 дүгээр зургаас харах - Навчин наамлаар хийсэн амьтдын тухай өөрийн мэдэх зүйлээр бусадтай ярилцах - Ургамлын мөчрийг янз бүийн хэлбэрээр байршуулан нарийн резинээр холбож зургийн жааз бүтээх - Бүтээсэн жаазаар навч, боргоцой зэрэг зүйлсээр чимэглэх	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х8,9 - Ургамлын хатсан навч, мөчир, үндэс, иш, боргоцой, цэцгийн хатаамал, самрын яс - Нарийн резин - Баримлын шавар - Байгалийн сэдэвт зураг

3.2и. Янз бүрийн материалыг будаж хооронд нь холбох, хайчлах, чимэглэх аргаар бүтээл хийх	- Нэг удаагийн цаасан аяга, таваг, төрөл бүрийн цаасан хайрцаг, мөхөөлдөсний савх мод, товч зэрэг янз бүрийн материал цуглуулж, хийх зүйлдээ сонгох - Цаасан аяга, таваг, хайрцагны хэлбэрийг хайчлах аргаар хийх зүйлдээ тохируулан өөрчлөх - Бүрдэл хэсгүүдийн хооронд нь холбож, нэгэн биет зүйл бүтээж төрөл бүрийн аргаар чимэглэх - Сурах бичгийн 72-р хуудасны цаасан аягаар онгоцны загвар, 73-р хуудасны “Муур”-ны загварыг хэрхэн яаж хийсэн аргачлалыг хийж буй зүйлдээ ашиглах <i>/Бага ангийн сургалтанд янз бүрийн материалыг ашиглах нь тогтвортой хөгжлийн боловсролтой холбоотой. 2002 онд “Даян дэлхийн тогтвортой хөгжлийн чуулган”-аас тогтвортой хөгжлийн боловсрол нь бидний ирээдүйдээ оруулж буй хөрөнгө оруулалт гэж тодорхойлсон байдаг. Тэгвэл технологийн бага боловсролд тогтвортой хөгжлийн боловсролыг тусгах дараах арга зам байна гэж үздэг/.</i> - Эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдыг дахин ашиглах - Технологийн бага боловсрол, сургалтаар бүтээж байгаа эд зүйлстэй нь холбоотойгоор байгаль орчноо хамгаалах үзэл бодол төлөвшүүлэх - Юмсыг гоё сайхан хийх дизайны /хэлбэр, өнгийн зохицол/ тухай ойлголттой болоход оршино.	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ., 2015 он. Х72, 73 - Нимгэн картон - Цаасны хайч, - Цаасны цавуу - Савх мод - Нарийн резин - Усан будаг - Скоч - Бөглөө
3.2к. Баримлын шавраар хийсэн энгийн геометр биетүүдийг өрж холбох аргаар хэлбэрийг өөрчлөх, хувиргах	- Гурвалжин, ам дөрвөлжин, дугуй дүрсийг конус, шоо, бөмбөрцөг биеттэй харьцуулж, адил төстэй ба ялгааг тайлбарлах - Конус, шоо, бөмбөрцөг биет ямар юмстай төстэй болохыг өөрийн бодол төсөөллөөр илэрхийлэх - Баримлын шавраар шоо, параллелолипед, цилиндр, конус, бөмбөрцөг биетүүд барих - Баримлын шавраар барьсан биетүүдээ хооронд нь өрж холбох аргаар биет загвар бүтээх, биетүүдийн байрлалыг нь өөрчлөх аргаар загварын хэлбэрийг нь өөрчлөх	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х 48 - Баримлын шавар - Нойтон алчуур - Хулдаас
3.2л. Баримлаар хийсэн амьтад, юмсын загварыг зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээх	- “Усанд амьдардаг амьтад”, “Хөдөө нутаг”, “Зуны зугаатай өдөр”, “Гэрийн тэжээмэл амьтад” зэрэг сэдвээр ярилцах - Үйл явдал илэрхийлсэн баримлыг бүтээхдээ: - Баримлыг биет байдлаар хийж, устай шилэн саван дотор байрлуулах - Хавтгай дээр зохиомжлон байрлуулах - Баримлын шаврыг цаасан дээр нялж наах аргыг ашиглах - Дээрх 3 аргаар хэрхэн баримал бүтээснийг сурах бичгийн 52, 53-р хуудаснаас судлах - Багшаас сурагчдыг багаар зохион байгуулж, баг бүр сонирхсон сэдвээр баримал барина. Багууд бүтээлээрээ үзэсгэлэн зохион байгуулж, бусдаас суралцаж туршлагаа хуваалцана.	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. Х 52-53 - Баримлын шавар - Нойтон алчуур - Хулдаас - Устагтай сав, утас - Төмөр цагираг - Зургийн дэвтрийн цаас

3.2м. Өнгийн ноосон утас ашиглан бөмбөлөг хийх аргаар бүтээл хийх	- Өнгө өнгийн ноосон утсыг 20-25 давхарлан уртааш нь зэрэгцүүлэн байрлуулах - Утсаа багцалж боож өгөх - Багцалж боосон утасны дунд хэсгээр хайчилснаар бөмбөлөг бэлэн болно. - Утсан бөмбөлөгтөө торгоны өөдөс, товч, сувс зэргийг ашиглан бүтээл хийх - Ноосон утсан бөмбөлөгөөрөө зүүлт, чимэглэл хийх Сурах бичгийн хуудас 64-ийн 4.13 дугаар зургийн аргачлалаар хийнэ.	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III.3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. X 64 - Өнгийн утас - Цаасны хайч - Товч, сувс
3.2н. Зүүлтийн гоёл чимэглэлд өнгийн ноосон утсыг хатуу цаасанд ороох, цаасны ирмэг дагуу хайчлах, цацагласан утсаа цагцалж боох аргыг ашиглах	- Ямар амьтан юуг энэ аргаар хийж болохыг өөр хоорондоо ярилцах - Сурах бичгийн 65-р хуудасны “Бамбарууш”, “Зараа”, “Дэгдээхий”-г хийсэн аргыг судлах - Сурах бичгийн 65, 69-р хуудасны дадлага ажлуудаас сонгож хийх. Үйл ажиллагааны дараалал нь: 1. Хатуу цаасан дээрээ хийх амьтны зургаа зурна. 2. Амьтны зургийн их биеийн гол хэсэгт ноосон утсыг сүвлэх нүх гаргана. 3. Ноосон утсаа нүхэнд сүвлэж, их биеийг бүхэлд нь ороох эсвэл цаасны ирмэг дагуулан ороосон утсаа хайчилна.	Д.Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи III. 3 дугаар ангийн сурах бичиг. УБ.,2015 он. X 65,68, 69 - Өнгийн ноосон утас - Хатуу цаас - Цаасны хайч - Фломастр - Харандаа

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ

4.1 ДҮРСЛЭХ УРЛАГ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.1а. Өнгийн хүрднээс эсрэг өнгийг байрлалаар нь ялгаж, эсрэг өнгийн ялгарлыг ажиглан тодорхойлох	<i>/Багш самбарт эсрэг өнгөөр дүрслэсэн зураг, цаасан наамлын бүтээл байрлуулсан байна./</i> - Сурагчид нэг минут орчим харьцуулан ажиглах - Ямар өнгө байсныг бусаддаа өргөн харуулж ярилцах. <i>/Самбарт үндсэн гурван өнгөтэй өнгийн хүрдийг байрлуулна/.</i> - Сурагчид өнгийн хүрдны эсрэг хоосон зайд ямар өнгө байрлахыг туршилтаар тогтоож, харьцуулан ялгааг тайлбарлах - Өнгийн дэвсгэрт дээр эсрэг өнийн цаас нааж, мэдлэгээ шалгах	Эсрэг өнгийн бүтээл АЗ-2ш соронз, зургийн дэвтэр, гуаш, усан будаг, бийр, нийлүүр, устай сав, нойтон цаас, өнгийн цаас, хайч, цавуу, сурах бичиг
4.1б. Эсрэг өнгийн ялгарлыг зураг дүрслэлдээ ашиглах	Сурагчид нэг өнгийг сонгон бусаддаа харуулах ба өргөсөн өнгөний эсрэг өнгийг бусад сурагчид өргөж дүгнэлт хийн ярилцах <i>/Багш сурагчдын тоогоор А6 хэмжээтэй ватум цаас тарааж, тэгш хэмтэй нугалуулан гуашийг өтгөвтөр найруулан нэг талд нь улаан, нөгөө талд ногоон өнгө гэх мэтээр дусаан хавсаргах туршилтаар эсрэг өнгүүд бие, биенээ тод харагдуулдаг онцлогтойг ойлгуулна/.</i> - Сурагчид чөлөөт сэдвээр эсрэг өнгийн зохиомж үүсгэн туршилтаар баталгаажуулах ба бусдынхаа бүтээлтэй харьцуулан ярилцах	А6-ТӨМ, гуаш, бийр Усны сав, усан будаг, нийлүүр, алчуур, зургийн дэвтэр

4.1в. Төрөл бүрийн материалаар толболох аргыг зураг дүрслэлдээ ашиглах	<i>/Багш 3-р ангидаа туршсан санамсаргүйгээр толбо үүсгэх, үндсэн дүрсийг дардаслан олшруулах аргыг сэргээн сануулж ярилцана/</i> - Төмсийг хувааж, дүрс, хэлбэрт оруулан товойлгон сийлэх, Хушигны ясыг таллан хувааж, цавуугаар кардон цаасан бариул нааж, кардон цаасыг нугалах, хуйлах аргаар хэвүүд үүсгэх - Гуашийг өтгөвтөр найруулан хавтгай бийрээр дардсан хэвэн дээр будаг түрхэж, толбо үүсгэн чөлөөт зохиомж хийх	- Төмс, хушигны яс, - кардон цаасан, - дардсан-ТӨМ, - гуаш, усан будаг, - бийр, будгийн нийлүүр, - устай сав, зургийн - дэвтэр
4.1г. Хөгжмийн аялгууг сонсоод зураасны төрлүүдээр илэрхийлэх	<i>/Зураасны онцлогыг сурах бичгээс уншуулж, ярилцана. Хөгжмийн 2-3 ая сонсгоно./</i> Сурагчид төрсөн сэтгэгдлээ төсөөлөн бодоод слайд дээр эсрэг өнгийн эсгий балаар хөгжмийн хэмнэлыг зураасаар нэг минутанд дүрслээд өргөн харуулж ярилцах. Туршилтаас төрсөн сэтгэгдлээ зураас, өнгөөр дүрслэн илэрхийлж, харьцуулан ярилцах.	- Өсгөгч, компьютер - Слайд-ТӨМ, - зургийн дэвтэр, усан будаг, гуаш, бийр, устай сав, будгийн нийлүүр, нойтон алчуур, зураачид, сурагчдын бүтээл
4.1д. Нэг төвт зохиомжийн онцлогийг зураачдын бүтээлийн жишээн дээр тайлбарлах	- Нэг төвт бүтээл, зураг, зохиомжийн тулгуур дохиог ажиглан гол ба туслах дүрийг хэрхэн байршуулан дүрсэлснийг харьцуулан ярилцах - Самбарт хүүхэлдэйн баатруудын дүрсэн хэвүүдийг нэг төвт зохиомжийн аргаар соронз ашиглан байршуулах дасгалыг гүйцэтгэх - “Миний дүү” сэдвээр нэг төвт зохиомжоор дүрслэх будах	- Сурах бичиг, зурагт үзүүлэн, усан будаг, гуашь, - бийр, устай сав, будгийн нийлүүр, зургийн дэвтэр
4.1е. Үндсэн дүрс ба биетийг зурахдаа орон зайн ялгааг анзаарах	<i>/Багш самбарт үндсэн дүрс, биетийг зааглан соронзоор тогтоож бэлтгэсэн байна./</i> - Дүрс ба биетийн ялгааг ажиглан ярилцах - Самбарт багш наана, цаана байршсан хоёр ижил дүрс зураад, энэ дүрсийг зураасаар яаж холбовол биет болон дүрслэгдэх вэ? гэдгийг слайд дээр, эсгий балаар зурж турших дадлага хийх <i>/Дүрсийг зураасаар зөв холбосон сурагчийг самбарт гаргаж, зуруулж сэдэлжүүлнэ./</i> - Сурагчид самбарт байршсан үндсэн дүрсээс сонгож, зургийн дэвтэртээ, дээрх туршилтын аргаар биет зурж, гурван талыг ойролцоо өнгөөр жигд таглан будах дадлага хийх	Үндсэн дүрс, биетийн дүрсэн, үзүүлэн, соронз, слайд-ТӨМ, эсгий бал, зургийн дэвтэр будаг, бийр, будгийн нийлүүр
4.1ж. Амьтны биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан дүрслэх	- Мал, амьтны донж, хөдөлгөөнийг хялбар, дүрс, зураасаар дүрсэлсэн араг, бодит зургийн үзүүлэнг самбарт байрлуулан харьцуулж, ажиглуулан ярилцах - Слайд дээр эсгий балаар таталбар зургийг 3 минут орчим дүрслэн, өргөн харуулж ярилцах - Сурах бичигт байгаа, мал, амьтны ерөнхий донж, хөдөлгөөнийг зурах аргачлалын дагуу зургийн дэвтэртээ дуртай амьтнаа баримжаалан зурж, дүрслэх	Зурагт үзүүлэн, слайд-ТӨМ, эсгий бал, будаг, бийр, будгийн нийлүүр, сурах бичиг, зургийн дэвтэр

4.1з. Араг зургийн аргаар амьтдын хөдөлгөөнийг дүрслэх	<i>/Багш самбарт таван хошуу малын араг зургийг хялбар цөөн зураасаар татаж, ямар малын донж, хөдөлгөөнийг дүрсэлсэн араг вэ? гэдгийг хэлүүлнэ/.</i> - Сурах бичигт байгаа мал, амьтны дүрс, донж, хөдөлгөөнийг, арагтай нь харьцуулан ажиглах <i>/Багш дэлгэцээр хадны зургийг хэсгээс харуулж, ямар амьтны араг зураг дүрсэлсэн байгааг нэрлүүлнэ/.</i> - Хадны зурагт дүрслэгдсэн амьтдын арагаас сонгож, зургийн дэвтэртээ донж, хөдөлгөөнийг сурах бичгийн аргачлалын дагуу дүрслэн үзүүлж, өнгө зүсийг усан будгаар будаж, харуулах	Шохой,алчуур, сурах бичиг, компьютер, дэлгэц зургийн дэвтэр, харандаа, баллуур усан будаг, бийр усны сав,
4.1и. Хүүхдийн болон монгол зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах	<i>/Багш самбарт уран зураг уншихдаа юуг анхаарах вэ? дарааллыг байрлуулна/.</i> - Сурах бичгээс зураач Х.Энхномин "Гэр бүл", Д.Бадамын "Төрсөн нутаг", Т.Нурмаажав, "Дэлхий ээж" бүтээлийг тайлбарлан ярилцах /гурван салаанд хуваарилан, самбарт байршуулсан асуултын дагуу 8-10 минут орчим уншуулж, товч бичүүлээд, ном, дэвтрийг хаалгаад, дэлгэцээр (самбарт) бүтээлийг тайлбаргүйгээр харуулан нэг салаа 5 минут орчим тайлбарлан ярилцана. Бусад багууд анхааралтай ажиглан санал, бодлоо илэрхийлж болно/. - Бусаддаа бүтээлээ тайлбарлан таниулсаны дараа хооронд нь харьцуулан, ижил ба ялгаатай талыг дүгнэн ярилцах <i>/Гэрийн даалгаварт бүтээлээ сольж унших, товч тайлбар бичиж ирэх даалгавар өгч болох юм/.</i>	Сурах бичиг, дэлгэц, цахим болон зурагт үзүүлэн /зураачийн бүтээл- А3-3ш/ дэвтэр, үзэг
4.1к. Мартан, нагтан зургийн аргаар өөрийн бодол төсөөллийг дүрслэх	- Мартан, нагтан зургийн аргаар зурсан зургуудыг харуулан сурагчдад төрсөн сэтгэдлийн талаар таамаглал дэвшүүлэн ярилцах. - Сурагчдад сурах бичгээс тодорхойлолтыг бичүүлж, зурах дарааллыг унших - Зургийн дэвтрийн хоёр хуудсанд улаан, хар- А4 өнгийн цаас наах - Хөгжмийн ая сонсох, шүлэг уншуулж, үйл явдлыг харандаа, штрих, бийрээр зурааслан зурах	А3-А2 бүтээл, өнгийн цаас, цавуу штрих, зургийн харандаа, будаг, бийр, будгийн нийлүүр, усны сав, дэвтэр, компьютер, өсгөгч

4.2 ТЕХНОЛОГИ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.2а. Цаасны үүсэл болон боловсруулах үе шатыг жишээн дээр тайлбарлах	- Ижил хэмжээтэй, зузаан, нимгэн олон янзын цаасыг нугалах, хуйлах, хайчлах туршилт хийх - Бат бөх шинж чанар болон гадаад өнгө, үзэмжийг нь тодорхойлон ярилцах - Цаасны төрөл болон зориулалтыг хамтран тодорхойлох жишээ гарган тайлбарлах - Цаасны үүсэл, цаас боловсруулах талаар өөрсдийн бодол төсөөллөө хуваалцах - Сурах бичиг дээрх цаасны үүсэл, боловсруулах технологи үе шатыг харуулсан зураглалыг багаар эсвэл хосоор хамтран хийх - Зураглалыг жишээгээр тайлбарлах - Цаасны зохистой хэрэглээний талаар асуудал дэвшүүлэн ярилцах <i>/Багшийн анхаарах зүйл: Хичээлийн багаар эсвэл хосоор зохион байгуулж болно. Цаас нь байгалийн гаралтай бүтээгдэхүүн болох, цаасны зохистой хэрэглээг сурагчдад ойлгуулахдаа: Хүүхэд бүр байгалиа хамгаалахад хувь нэмэр оруулж болохыг цаасны хэрэглээтэй холбон асуудал дэвшүүлэн ярилцах замаар сурагчдыг чиглүүлж болох юм/.</i>	Ижил хэмжээтэй, зузаан, нимгэн төрөл бүрийн цаас Хайч, шугам, дэвтэр, үзэг Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг. Хуудас 32-33. Зургийн дэвтэр, өнгийн цаас
4.2б. Цаасан хайрцаг задалж геометр биетийн дэлгээс судалж тайлбарлах	- Савангийн хайрцаг, төрсөн өдрийн малгай, цаасан аяга зэрэг цаасаар хийсэн хайрцаг, савнуудыг наалтаар нь задлах - Задалсан дэлгээсүүдийн хэлбэрийг ажиглах, шугамаар хэмжиж дэвтэртээ дэлгээсийн дүрслэх - Үүссэн хэлбэрийг харьцуулж тайлбарлах - Дэлгээсийн талаарх ойлголтоо жишээгээр тайлбарлах	Савангийн хайрцаг, төрсөн өдрийн малгай, цаасан аяга Зургийн дэвтэр, шугам, гортиг, харандаа
4.2в. Тэгш өнцөгт биетийн дэлгээс байгуулах аргаар тоглоомын загвар бүтээх	- Тэгш өнцөгт цаасан хайрцгийн тал, орой, ирмэгийг тоолох - Цаасан хайрцгийг наалтаар задалж, ярилцах - Ярилцах чиглэл: – Хайрцгийн дэлгээс хэдэн тэгш өнцөгт дүрсээс бүрдсэн эсэх – Хайрцаг хэдэн ижил тал байгаа эсэх – Хайрцгийн дэлгээсийн нугалах шугам хэд байгаа эсэх – Хайрцгийн наах хэсэг хэд байгаа эсэх - Хайрцгийн дэлгээсийг шугамаар хэмжээд зургийн дэвтэрт наах хэсгийн хамт буулган зурах - Нугалах, хайчлах, наах хэсгийг тэмдэглэх - Зурсан дэлгээс хайчилж, биет бүтээх - Бүтээсэн тэгш өнцөгт биетийн бүрдэл хэсгийн тоог нэмэх аргаар загварчилж чимэглэн будах - Бүтээлээ сайжруулах, өөрчлөх, хувиргах санаа гаргах тайлбарлах <i>/Багшийн анхаарах зүйл: Багш сурагчдын авч ирэх цаасан хайрцгийн талаар урьдчилан зөвлөх хэрэгтэй. Овор хэмжээ багатай ахуйн хэрэглээний аюулгүй бараа бүтээгдэхүүний тэгш өнцөгт хэлбэртэй цаасан хайрцаг /саван, жигнэмэг/ хэрэглэнэ/.</i>	Тэгш өнцөгт цаасан хайрцаг, сав Зургийн дэвтэр, шугам, харандаа, баллуур, хайч, цавуу Өнгийн цаас, өнгийн будаг, чимэглэлийн материал, скоч Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг. хуудас 24-25


4.2г. Хавтгай дүрсүүдийг сэтэлж хайчлах аргаар холбож 3 хэмжээст бүтээл хийх	- Сурах бичгээс хавтгай дүрс ашиглан хийсэн тоглоомын зургийг ажиглан ярилцах /ямар амьтны дүрслэл, юугаар, яаж хийсэн болох талаар/ - Хатуу цаасан дээр зурсан амьтны бүрдэл хэсгүүдийг баг гишүүд хайчилж бэлтгэх - Бүрдэл хэсгүүдийг өнгө тохируулан будах - Бүрдэл хэсгүүдийн сэтэлж хайчлан холбох хэсгийг бэлтгэх - Холбох хэсгээр нь угсрах - Багууд сэтэлж хайчлан холбох аргаараа өөр ямар нэгэн амьтан хийх - Хийх аргыг тайлбарлах, эргэлзээтэй байгаа нөхөддөө зааж өгөх - Хийсэн тоглоомоо чимэглэх - Бүтээлийг өөрчлөх, хувиргах санаа гаргах тайлбарлах <i>Багшийн анхаарах зүйл: Багшаас сурагчдыг сэдэлжүүлэхийн тулд амьтны хүрээлэнгийн хашаа байгуулан байрлуулах хэрэгтэй. Сурагчид хийсэн амьтдаа амьтны хүрээлэндээ байрлуулан хамтын бүтээл хийж болох юм.</i>	Олон ижил дүрсээр биет хийсэн тоглоомын загвар, зураг, шугам, харандаа, хайч, цавуу, картон цаас, утас Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг. хуудас 16-17
4.2д. Төрөл бүрийн биетүүдийг загварчлах аргаар бүтээл хийх	- Хаягдал сав баглаа боодол буюу цаасан хайрцаг, хуванцар сав зэрэг хэрэглээнээс гарсан янз бүрийн материалуудыг бэлтгэсэн байх - Эргэн тойрны эд зүйлсийг геометрийн биетүүдтэй холбон ярилцах - Материал хэрэглэгдэхүүнийг сонгох - Сонгон авсан материалуудаар (Хаягдал сав баглаа боодол буюу цаасан хайрцаг, хуванцар сав зэргээр) өрж, угсарч, давхарлах байдлаар юу хийхээ төлөвлөх - Төлөвлөсөн зүйлээ бүтээх - Бүтээл хийх явцдаа цаас, картоныг нугалах, хайчлах, базах, зүсэх, хуйлах, аргыг ашиглах - Бүтээлээ будах, чимэглэх - Хийсэн бүтээлдээ үнэлэлт дүгнэлт өгөх, Бүтээлийн хэрэглээг тайлбарлах сайжруулах санал гаргах <i>Багшийн анхаарах зүйл: Сурагчдыг баг болгон хамтын бүтээл хийлгэж болно. Сурагчдыг зөвхөн сурах бичгийн агуулгын хүрээнд хязгаарлах бус тэдний сэтгэн бодох, зохион бүтээх өөрийн санаагаа хэрэгжүүлэх боломжийг өгөх зүйтэй.</i>	Хайрцаг, сав, зайрмагны аяга Бэлэгний тууз, наалт, сувс, зураг зэрэг чимэглэлийн материал Хайч, цавуу, өнгийн цаас, харандаа, зургийн хэрэгсэл Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг. хуудас 28-29

4.2е. Туузан цаасыг хэлбэр үүсгэн холбох аргаар 3 хэмжээст чимэглэлийн бүтээл хийх	- Багшийн бэлтгэсэн нугалан хайчилж янз бүрийн цаасан чимэглэл, тоглоом хийх зурган заавар бүхий хуудастай танилцах - Заавар зургаас сонгох, хийх аргыг судлах - Заавар зургийн дагуу цаас нугалах, хайчилж шинэ жилийн сүлд модны тоглоом, чимэглэл хийх - Хийсэн чимэглэл тоглоом, хийх арга барилаас санаа авч өөрсдөө шинэ хээ, зураг зохиож шинэ жилийн чимэглэл тоглоомууд хийх. - Ангиа чимэглэх <i>/Багшийн анхаарах зүйл: Тухайн агуулгыг шинэ жилийн баяр угтан хэрэгжүүлэх нь тохиромжтой. Сурагчид өөрсдийн хийсэн чимэглэлээр сургууль, ангиа чимэглэж болно. Даалгаврыг гүйцэтгэх явцад багш үдээсний машинтай аюулгүй ажиллах дүрмийг баримтлахыг сануулах хэрэгтэй/.</i>	Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг хуудас 30-37. Цаасан чимэглэл-бодит үзүүлэнгүүд Өнгийн цаас, өнгийн будаг, чимэглэлийн материал наалддаг тууз Зургийн дэвтэр, шугам, гортиг, харандаа, баллуур, хайч, цавуу
4.2ж. Шигтгэж чимэглэл хийхэд байгалийн материал (будaa, чулуу, самрын яс)-ыг ашиглах	- Сурагч бүр будаа, чулуу, самрын яс, тариа буудай зэргээс сонгож бэлтгэсэн байх - Бэлтгэсэн материалуудаа нийлүүлэн нэг ширээнд байрлуулан дараах чиглэлээр ярилцах /Тухайн байгалийн юмстай холбоотой өөрийн мэдэх бүх зүйлийг бичих\ Ямар амьтны хоол тэжээл болдог, тэдгээрийг юунд ашигладаг г.м. - Хэнд, юунд зориулж юу хийх талаараа ажлын хуудсанд зорилгоо бичих. - Багшийн үзүүлж буй биет болон зурагт үзүүлэнгээс санаа авч ямар бүтээл хийхээ төлөвлөх - Сонгосон материалаа ашиглан баримлын шавар дээр наах аргаар бэлэг дурсгалын зүйл хийх - Хичээлийн төгсгөлд үзэсгэлэн зохион байгуулах - Үзэсгэлэнг үзэх явцад бусдын бүтээлээс олж авсан шинэ санаа, арга барилтай холбоотой тэмдэглэл хөтлөх, өөрсдийн бүтээлд үнэлэлт дүгнэлт өгөх - Гэрийн даалгавар юу хийхээ төлөвлөх, санал гаргах <i>/Багшийн анхаарах зүйл: Тухайн агуулгын хэрэгжүүлэхдээ сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэх хэрэгтэй ба сурагчдад сэтгэн бодох, зохион бүтээх өөрийн санаагаа хэрэгжүүлэх боломжийг өгөх зүйтэй/.</i>	чихэр, шоколадны цуглуулганы хайрцаг, баримлын шавар, байгалийн материал (чулуу, сам, өндөгний хальс., будаа, зэрэг) Зурагт болон биет үзүүлэн Зураг бүхий үзүүлэн Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг хуудас 7-8.

4.2з. Цаасыг хэлбэрт оруулж тугалган цаасаар бүрэх аргаар амьтдын баримал урлах	- Баримлын төрлийн зургуудыг ажиглан гурван хэмжээст бүтээлийн онцлогийг ярилцах - Баримал урлан бүтээх. - Тогоруу шувуу хийх: – Өнгийн цаасыг тогорууны хэлбэрт оруулж скочоор ороох. – Тогорууны биеийг тугалган цаасаар бүрэх – Тогорууны хөлийг савх модоор хийж сарвууг баримлын шавраар хийж тогтоох – Бүтээлийг хувирган өөрчлөх – Бүтээлийг сайжруулах шинэ санаа, арга барил танилцуулах /Шинэ бүтээл хийх санаа гаргах/ <i>Багшийн анхаарах зүйл:</i> <i>/Сурагчид баримал урлах багаж хэрэгслийг зөв ашиглаж байгаа эсэхийг анхаарах, ажиллагааны үед аюулгүй ажиллагааг байнга сануулж байх хэрэгтэй.</i> <i>Мэдээлэл: Уран баримал нь байгаль нийгмийн үзэгдэл, юмс түүний дүр төрхийг биет, бодитоор харуулдаг урлаг юм. Уран баримлыг мод, шавар, чулуу, төмөр хүрэл болон сүүлийн үед хиймэл материалаар урладаг болсон/.</i>	Баримлын шавар, хүнсний тугалган цаас, өнгийн цаас, скоч, хөвөн, савх мод, цаасны цавуу, хайч Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг хуудас 56-57
4.2и. Хаягдал материалаар хүндрүүлэгч ачаа, харимхай металл салхины хүч ашиглан техникийн загвар бүтээх	- Сурагчид төрөл бүрийн цаасан хайрцаг, хуванцар сав бэлтгэсэн байх - Бэлтгэсэн материалуудаас багууд сонгон авто машины ямар загвар яаж хийх тухайгаа ярилцах, төлөвлөгөө гаргах - Төлөвлөгөөний дагуу хэн юу хийхээ хуваарилан машины загвар хийх - Бүтээсэн загвартаа ямар хөдөлгүүр тавьж болох, чимэглэлийг яаж хийхээ хамтран ярилцах - Ажил үүргээ хуваарилах - Төлөвлөлтийн дагуу техникийн загвар хамтран хийх - Бүтээсэн машинуудаа уралдуулах - Бөмбөлөг ашиглан хөдөлгүүр хийж, туршиж явуулах. - Хийсэн загваруудаа улам сайжруулах, хурдлуулах, тэнцвэртэй болгох талаар санаа олох, турших. - Техникийн загвараа илүү сайжруулах талаар ярилцах бүтээлээ бусаддаа танилцуулах <i>/Багшийн анхаарах зүйл: Багш тухайн агуулгыг хэрэгжүүлэхдээ сурагчдыг багаар зохион байгуулж болно. Техникийн загварын бүрдэл хэсгийг хийхэд багш дэмжлэг үзүүлэх, цаас, кардоноор дугуй хийх аргыг зааварчлах хэрэгтэй. Мөн хөдөлгүүрийн төрлүүдийг багш хамтран турших нь зүйтэй/.</i>	Бөмбөлөг Ундааны сав Хаягдал материал, хайрцаг, бөглөө Машины зураг Сурах бичиг Хатуу цаас /картон/, хайч, усан будаг, бийр, цавуу, балын харандаа, баллуур, шугам, онгоцны дэлгээс зураг Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг хуудас 46-47

4.2к. Гар оёдлын багаж хэрэгслийг жижиг эдлэл хийхэд ашиглах	Гар оёдлын багаж хэрэгслийг хэрэглэн турших: - Жижигхэн хэмжээтэй даавууны өөдсийг багш сурагчдад үзүүлэх - Түүнийг ашиглан юу хийж болох тухай, хэрхэн яаж хийх талаар сурагчид саналаа хэлэх - Сурагч бүр дэвтэртээ дээрх жижигхэн даавуугаар хийж болох зүйлүүдийг зураад тайлбар бичих - Гар оёдлын багаж хэрэгслүүдтэй танилцах, зураг дээр ярилцах - Гар оёдлын багаж хэрэгслүүд хэрхэн яаж зөв хэрэглэх болон аюулгүй ажиллагааны дүрмийг ойлгох, дэвтэртээ тэмдэглэх - Багш хүүхэд бүр 20:20 см хэмжээтэй даавуу бэлтгэх - Хөших болон шидэх оёдлыг хэрхэн зөв оёх зурагт үзүүлэнг ажиглах - Сурагчид дэвтэртээ ямар нэг дүрс зураад, зүүгээ сүвлэн шидэх, хөших оёдлоор оёж сурах дадлага хийх <i>/Гэрийн даалгаварт: Жижигхэн даавуугаар юу хийх талаар гэр бүлийнхэнтэйгээ зөвлөж дэвтэртээ зурж ирэх/</i> Жижиг эдлэл хийх: - Даавуугаараа юу хийхээр шийдсэнээ ярилцах - Зурж, нааж бэлтгэсэн загвараа үзүүлэх - Жижигхэн даавуун уут, түрүүвч, хайчны гэр, зүүний хатгуур, тоглоом зэрэг зүйлүүдээс сурагчид хийх зүйлээ сонгож эсгүүрийг цаасан дээр хэмжиж зураад хайчлах - Багш оёдолчин, эсгүүрчин, загвар зохион бүтээгч мэргэжлийн талаар танилцуулж, юу хийдэг талаар ярилцах - Багшийн зааварчилгаар жижиг эдлэлээ хийх - Хийсэн зүйлээ хэрхэн чимэглэх талаар өөр хоорондоо ярилцах - Хийсэн бүтээлээ зургийн дагуу болсон эсэхэд дүгнэлт хийн ярилцах - Хийсэн зүйлээ товчоор, сувсаа, цацгаар чимэглэх байдлаар хувиргах, өөрчлөх түүнийгээ тайлбарлах <i>/Багшийн анхаарах зүйл: Тухайн ангийн агуулгын хүрээнд зөвхөн сурагчид оролцохоос гадна хийх эдлэлийг сонгох, хийх, чимэглэх зэрэгт сурагчдын гэр бүлийнхнийг оролцуулан хүүхэдтэйгээ хамтрах, хамтын бүтээл гаргуулах тал дээр багш нар анхаарч ажиллах нь зүйтэй/.</i>	Сэмрэлт багатай, биетэй, цулгай өнгийн даавуу /Гал тогооны 3 өнгийн алчуур/ Дэвтэр, үзэг, харандаа, өнгийн харандаа Хөших болон шидэх оёдлыг хэрхэн зөв оёх зурагт үзүүлэн Зүү, утас, хайч Даавуугаар хийх жижиг эдлэлийг харуулсан зурагт болон биет үзүүлэн Зүү, утас, хайч Товч,сувс, өнгийн утас Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг хуудас 40-41
---	---	---

	/Зүү, утас, хайчтай ажиллах аюулгүй ажиллагааны дүрмийг том цаасан дээр зурж, хэвлээд улирлын турш ангидаа өлгөөрэй. Хөших шидэх оёдлоор оёж сурахад нь хүүхэд нэг бүрт багш биечлэн зааж өгнө. Хүүхэд бүрийн хийсэн эдлэл дараа нь хэрэглэж болохоор байх тал дээр анхаарч тэдэнд туслан, зөвлөж, хамтран ажиллах хэрэгтэй. Хүүхэд бүрээс бүтээл гарсан байх ёстой. Хичээлийн явцад хүүхдүүдийн ур чадвар, туршлагаас хамааруулан багш дотроо тэднийг хэд хэдэн хэсэгт хамааруулан хичээл дээр гүйцэтгэх даалгаврыг ялгаатай байдлаар бэлдэн өгч болно. Үүнд: ○ Оёх, хатгах туршлагатай сурагчид: Урьд өмнө нь ээж, эгч, эмээгээрээ заалган оёж сурсан, оёх, хатгах тодорхой хэмжээний туршлагатай хүүхдүүдэд загвар, хийц, чимэглэлийн хувьд илүү хүндэрсэн даалгавар өгөх хэрэгтэй. ○ Оёх, хатгах тал дээр эв дүй муутай сурагчид: Тэдэнд оёдол, чимэглэлийн хувьд арай энгийн хялбар боловч сонирхолтой хэлбэр, загвартай зүйл сонгоход нь чиглүүлж өгөөрэй. Эдгээр сурагчдын хувьд “би хийж чадлаа” хэмээн урамших, өөртөө итгэх итгэлтэй болох нь хамгийн чухал. ○ Хөвгүүд: Оёдол эсгүүр бол охидын хийх ажил гэсэн ойлголт тэдэнд бий. Дэлхийн нэр алдартай дизайнерууд, гоёл чимэглэлийн бүтээл урладаг уран бүтээлчид ихэнх нь эрэгтэйчүүд байдаг тухай ярьж сэдэлжүүлж болно. Хөвгүүдийн анх оёж сурах даавуун дээр унадаг дугуй, машин, робот гэх мэт дүрсийг харандаагаар зурж бэлдсэн байж болно/.	
4.2л. 2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зууш бэлтгэх	Сурагчид гэрээсээ хүнсний бүтээгдэхүүн болон зууш бэлтгэх хэрэглэгдэхүүн бэлтгэн авч ирсэн байх /Жимс, жимсгэнэ: алим, гадил, тарвас, усан үзэм Бусад: талх, хиам, үрлэн улаан лооль, өргөст хэмх зэрэг хүнсний бүтээгдэхүүн салфетка, шүдний чигчлүүр эсвэл зориулалтын шор/ – Сурагчид авч ирсэн хүнсний бүтээгдэхүүнээ нэрлэх – Тухайн хүнсний бүтээгдэхүүнээр ямар зууш бэлтгэж болох талаар ярилцах – Жимс, жимсгэнэ бусад хүнсний бүтээгдэхүүнийг угаах, хальслах – Хүнсний бүтээгдэхүүн 0.5-1 см зузаантай, 2х2 эсвэл 3х3 хэмжээтэй зүсч бэлдэх /Зүсч бэлдэхдээ дөрвөлжин, дугуй, гурвалжин хэлбэртэй байж болно/ – Сурагч тус бүрдээ зуушны орцоо төлөвлөх – Зуушны орцод орох 2-3 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээ сонгох	Хутга Мах ногоо хэрчих мод Талх, Хачир хийх хүнсний бүтээгдэхүүнүүд Лууван, чанасан өндөг, майонез Салфетка Цаасан аяга, таваг Дэвтэр, үзэг, харандаа

	– Талхтай зууш эсвэл жимс, жимсгэний зууш шор хатган бэлтгэх – Өөрсдийн бэлтгэсэн зуушаар ширээ засан амталгаа хийх <i>/Багшийн анхаарах зүйл: Хүнсний бүтээгдэхүүнийг зүсч бэлдэхэд багш хамтарна. Хутгыг багшийн хяналтад аюулгүйн зааврын дагуу хэрэглэхийг сурагчид анхааруулна. Багш Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичгийн 20-21 хуудаснаас санаа авч болно. Сурагчдын бэлтгэх зууш нь 2-3 төрлийн орц найрлага байхыг анхаарах хэрэгтэй/.</i>	
4.2м. Ажил мэргэжлийн онцлогийг жишээгээр тайлбарлах	– Сурагчид эцэг, эх, гэр бүлийнхээ гишүүдийн юу хийдэг ажил мэргэжлийн онцлогийн талаар судалж тэмдэглэл хөтөлж ирсэн байх – Өөрсдийн гэр бүлийн хүмүүсийнхээ ажил мэргэжлийн талаар хамтран ярилцах – Багш, эмч, инженер, зохион бүтээгч, жолооч техниктэй холбоотой ажил мэргэжлийн харуулсан зурагт үзүүлэн үзүүлэх  – Ажил мэргэжлүүдийг нэрлэх, онцлог болон хаана, юу хийдэг болох, ямар ажлын багаж хэрэглэгдэхүүн хэрэглэдэг талаар багаараа ярилцан савар зураглал ашиглан санаагаа дэлгэрүүлнэ.  – Ажил мэргэжлийн онцлогийг тодорхойлох жишээгээр тайлбарлах <i>/Багшийн анхаарах зүйл: Ажил мэргэжлүүдтэй холбоотой зурагт үзүүлэн, видео бичлэгийг дараах хаягаар татаж аваарай. https://www.youtube.com/results?search_query=Jobs+and+Occupations Багш урьдчилан тайлбарлах, шууд зааж зөвлөхөөс татгалзаж, сурагчдаар өөрөө асуудлыг дэвшүүлэх боломжийг нээлттэй өгөх нь зүйтэй. Багш дөхүүлэх асуултаар дэмжиж туслах нь сурагчдын хөгжилд сайнаар нөлөөлнө/.</i>	Багш, эмч, инженер, зохион бүтээгч, жолооч техниктэй холбоотой ажил мэргэжлийн харуулсан зурагт үзүүлэн, видео бичлэг Ажлын хуудас Ажил хөдөлмөр: – Биеийн хүчний ажил – Оюуны хөдөлмөр Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 4 дүгээр ангийн сурах бичиг хуудас 68-69

ТАВДУГААР АНГИ

5.1 Дүрслэх урлаг

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.1а. Дүрслэх урлагийн төрөл зүйлээс жишээгээр тайлбарлах	<i>/Багш цахим хичээл бэлтгэсэн байна/.</i> - Дэлгэцээр дараах бүтээлүүд дүрслэх урлагийн ямар төрөлд хамаарагдах вэ? эсэхийг асууж сурагчдаар таамаглал дэвшүүлэн ярилцах - Самбарт дүрслэх урлагийн төрөлд хамаарагдах бүтээлийн фото зургуудыг байрлуулж, нэрийг зөв харгалзуулах дасгалыг сурагчид гүйцэтгэх - Сурах бичгийн мэдээллыг уншуулж, зураач, урчуудын нэр, бүтээлийн нэр, огноо, хэмжээ, ямар материалаар урлан бүтээсэн зэргийг бичих, тайлбарлан ярилцах Галарей, музей үзэж, эх бүтээлтэй нь танилцсан сэтгэгдлийг сонсох, фото,мэдээлэлээ хуваалцах	Дүрслэх урлагийн төрөл зүйл таниулах үзүүлэнгүүд, цахим хичээл, өнгөт зурагт бүтээлийн цуглуулга
5.1б. Өнгийн уламжлалт нэршил, бэлгэдлийг тайлбарлах, нэг өнгийг цайруулах аргыг зураг дүрслэлдээ ашиглах	- Сурах бичгээс бүл өнгө, солонгийн өнгө, зарц өнгөний нэршлийн мэдээллийг 5 минут орчим унших <i>/багш самбарт уламжлалт нэршлийн нэрүүд, өнгийн цаасуудыг байрлуулан, ялгах дасгалыг сурагчдаар хийлгэнэ/</i> - Өнгөний нэршил, бэлгэдлийг хооронд нь харгалзуулах, эцэг, эх өнгийг хооронд нь, хар ба цагаан өнгийг хольж, хүү, зарц өнгө үүсгэн турших, бүтээлдээ ашиглах - Эцэг өнгийг солонгын өнгөний дарааллаар хүрдэнд байршуулан будах	Сурах бичиг, өнгийн тест, зургийн дэвтэр, гуаш, усан будаг, бийр, нийлүүр, устай сав
5.1в. Биетийн гэрэл, сүүдрийг дүрслэхдээ цэглэх, толболох аргыг ашиглах	<i>/Багш 1,2-р ангидаа үзэж байсан цэглэх, толболох аргыг сэргээн сануулж ярилцаад, самбарт хүүхэд, зураачийн цэг, толбоор урласан бүтээл байрлуулах/</i> - Цэг, толбоны нягт, сийрэг байдал нь юуг илэрхийлж байгааг таамаглал дэвшүүлэн ярилцах - Самбарт соронзоор цагаан А1 цаасан фон байрлуулж, дээр нь хөнгөн биет, юмс <i>/чихмэл тоглоом, геометрийн шуумлан биет гэх мэт/</i> дүүжлэн байрлуулаад гэрэл, сүүдрийн зааг ялгааг тайлбарлан таамаглалаа нотлох - Сурагчдад самбарт өлгөсөн биетийн дүрсэн хэвүүд тарааж өгнө. <i>/Цахимаар туршилт бичлэг үзүүлж, сэдэлжүүлж болно/.</i> - Сурагчид хэвүүдээс сонгоод зургийн дэвтэртээ зохиомжлон буулган зураад, эсгий бал, үзгэн балны гол, хуйлсан цаас, туузлалсан хатуу цаас, ундааны соруул, өөрийн зохион хийсэн толбологч зэргийг ашиглан, гэрэл, сүүдрийн зааг, ялгарлыг толболом чимэглэл хийх	Толболом зурсан бүтээл, соронз, А1 цаас, биет дүрсүүд-ТӨМ, Цахим хичээл, гуаш, усан будаг, бийр, будгийн нийлүүр, алчуурууд, толбологчууд

5.1г. Задгай болон өнцөглөсөн зохиомжийн ялгааг харьцуулан зураачдын бүтээлийн жишээн дээр тайлбарлах	<i>/Багш самбарт Б.Шаравын "Монголын нэг өдөр", О.Цэвэгжавын "Ууланд" бүтээлийг байрлуулан зургийн гол ба туслах дүрүүд хэрхэн байршсан, хаанаас харж зурсан вэ? гэдгийг асууж, таамаглал дэвшүүлүүлэн ярилцана. А4 цаасан дээр тулгуур дохионы дүрсэн тэмдэглэгээ аль бүтээлд хамааралтай болохыг сурагчаар харгалзуулуулах/</i> Сурагчид дэвтэртээ: - Уудам орон зайд, дүрүүдийг чөлөөтэй байршуулсан нь задгай, Зургийн хавтгайн аль нэг өнцгөөс, эсрэг өнцөг рүү чиглэсэн, гол дүрийн байршил нь өнцөглөсөн зохиомжийн арга гэнэ тодорхойлолтыг тэмдэглэх - "Багын спорт", "Үлэг гүрвэлүүд" сэдвээр дээрх зохиомжийн аргын дагуу зурж дүрслэх	Зураачдын бүтээийн цомог, тулгуур дохионы үзүүлэн, соронз, сурах бичиг, зургийн дэвтэр, харандаа, баллуур
5.1д. Юмсын хол, ойр байршлыг нэг цэгийн алслалттай холбон тайлбарлах	- Сурах бичгээс энгийн аргаар, алслалтыг хэрхэн дүрсэлсэн эсэхийг ажиглуулж, ярилцах <i>/Самбарт тэнгэр, газрын фонтой (А1) формат дээр байшин барилга, гудамж, зам, гэрэлтүүлэгийн шон, машины байршлыг, нэг цэгийн алслалтын аргаар дүрс, өнгийг тохируулан зохиомжлон эвлүүлэх дасгалыг сурагчаар гүйцэтгүүлнэ. Сурагчдад дээрх дасгалтай ойролцоо кардон дүрсүүдын ТӨМ-г тарааж өгнө./</i> - Сурагчид өнгийн цаасан дээр дүрсэн хэвээ тавьж, тойруулан зурж, хайчлан, зургийн дэвтэртээ дээрх аргаар эвлүүлэн зохиомжлон нааж, нарийн зүйлсыг харандаа, эсгий балаар зурж, чимэглэх	Алслалт бүхий зураасдын уран зураг, алслалт үзүүлэн, зохиомж зураг, өнгийн цаас, шугам, хайч, цавуу, зургийн дэвтэр, харандаа, баллуур
5.1е. Юмсын хол, ойр байршлыг хүйтэн, дулаан өнгө, хүнд хөнгөн өнгийн ялгаатай холбон тайлбарлах	<i>/Багш самбарт АЗ-н дулаан, хүйтэн өнгөтэй байгалийн фото зураг байрлуулан, өнгө хэрхэн өөрчлөгдөж байгааг өнгийн цаас, харандаа будаг. эсгий балаар өнгийн дарааллыг зөв байршуулах дасгалыг 3 минутад хийлгэж, зэрэг өргүүлэн дүгнэн ярилцана. Үүнээс хүний нүдэнд ойртох дутамд өнгө нь тодорч, холдох дутамд өнгө бүдгэрч харагддаг ялгарлыг ойлгуулна./</i> – Уулс, байшингийн хол, ойр зурвасыг дүрслээд, солонгын өнгөн дээр, эх өнгийг дусал нэмэх аргаар будан, турших	Фото зургийн үзүүлэн, өнгийн, эсгий бал, харандаан будаг, гуаш, усан будаг, бийр, холигч, усны сав, зургийн дэвтэр
5.1ж. Хүний нүүрний хэсгүүдийн хэмжээ, харьцааг дүрслэх аргыг зураг дүрслэлдээ ашиглах	<i>/Багш нүүрний эрхтэн хоорондын зайг нүдэн баримжаагаар хэмжих аргыг өөр дээрээ харуулан дагуулна. Жишээлбэл: Зууван дугуйг тэнцүү хуваасан хэвтээ тэнхлэг дээр нүд байрлана. Нүдний өргөн толгойн өргөнд дөрөв дахин багтах ба хамрын өргөнтэй тэнцүү гэх зэргээр харьцуулах/</i> – Нүднээс дээш дахин нэг нүд багтах зайд хөмсөг зурах – Нүднээс эрүү хүртлэх зайг бараг таллан хуваагаад хамрын үзүүр түүнээс дооших зайг таллан хуваасан зайд ам байрлах	Слайд-ТӨМ, эсгий бал, харандаа, баллуур, зургийн дэвтэр, сурах бичиг

	– Хамрын үзүүр, хөмсөг хоёрын харалдаа чих зурах – Толгойн хуйхнаас дээш үс зурах – Хоёр нүдний харалдаа баримжаанд хүзүү зурагдана гэх мэт. – Слайд дээр эсрэг өнгийн эсгий балаар дээр аргыг сурагчид туршин зураад өргөн харуулж, харилцан ярилцах – Сурах бичгийн аргачлалыг ажиглан,өөрийн нүүрний төрхийг толинд харж баримжаалан зурах	
5.1з. Гадаадын зураачдын уран зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах	- Уран зургийг ямар дарааллаар уншиж байсан бэ? гэсэн асуултын дагуу ярилцах, - Сурах бичгийн асуултын дагуу товч тэмдэглэл бичих - Сурах бичиг дээрх зураачдын бүтээлийг ажиглах. - Сурагчдад төрсөн сэтгэгдлээ илэрхийлэх. <i>/Бусад сурагчдад нэмэлт тайлбар хийхийг нь нээлтэй үлдээнэ. Багш сурах бичигт бичигдээгүй сонирхолтой баримт, нэмэлт мэдээллийг сурагчдад ярьж өгч болно/.</i>	Нөөтбук, дэлгэц, цахим хичээл, цахим хаяг, онолын дэвтэр, үзэг, сурах бичиг, зураачдын бүтээлийн цомог
5.1и. Геометрийн дүрсийн гаралтай хээ угалзыг дүрслэх	<i>/Багш самбарт хээ угалзын хэсгээс А4-А3 цаасан дээр томруулан хувиласан дүрс зургууд байршуулаад, геометрийн дүрсийн хээ, угалзыг ялгуулна/.</i> - Сурах бичгээс хээ угалзын тодорхойлолт, бүтээх аргыг уншуулж, товч бичих - Зургийн дэвтрийн хуудсанд дөрвөлжин шугамтай гол цаасны хоёр үзүүрийг цавуудан наалгаж, самбарт дээд, доод, мөр хоорондын зайн хэмжээг тооцоолон бичиж, сурах бичгийн аргачлалын дагуу алхан хээний төрлийг зурах, зураасуудыг эсгий балаар тодруулан, харандаан будгаар жигд таглан будна. - А4-н өнгийн цаасыг уртаас нь гурван тэнцүү нугалан хувааж, уртын дагуу тэгш хэмтэй нугалуулж, алхан хээний тал картон дүрсийг дээр нь тохируулан тавьж, тойруулан зураад, зураасын дагуу, давхраар нь хайчлаад, тэнийлгэн, зургийн дэвтэрт шугамын дагуу наах	Хээ угалзын үзүүлэн-ТӨМ, дөрвөлжин дэвтрийн гол цаас, өнгийн А4 цаас, шугам, харандаа, баллуур, цавуу, эсгий бал, зургийн дэвтэр
5.1к. Түйхий ба их дагнаасыг харьцуулах онцлог, ялгааг тайлбарлах	<i>/Бид 2,3-р ангидаа хоёр ба гурван зурвасыг өнгөөр дагнааслан будах аргыг туршиж үзсэн тухай сэргээн ярилцаад, самбарт хүнд өнгөөс хөнгөнрүү, хөнгөн өнгөөс хүндрүү, гүн хүнд өнгийг хоёр талруу нь шатлан цайруулах дагнаасалсан тулгуур дохионы үзүүлэнг байрлуулан ажиглуулж, орон зай, эзэлхүүнтэй харагдах байдал, түйхий, их дагнаасын ялгааг ойлгуулна/.</i> Жишээлбэл: Б.Шарав “Монголын нэг өдөр”, “Намар” Д.Бадам “Нар хурайлсан наадам”, Т.Нурмаажав “Сэтгэл догдлуулсан зун” 2009 он, С.Цэнгэл “Бөх”, С.Хөгжилбаяр “Ирээдүй өнөөдрөөс эхэлнэ”, Э.Түвшинбаяр “Наадам” гэх мэт бүтээлүүдтэй танилцах, ярилцах	Дагнаасын Үзүүлэн,соронз, М.Баярмагнай “Тэнгэрийн үрс”2009 он, Т.Нурмаажав “Дэлхий ээж”, М.Чинбат нарын “Их хуралдай” 2011он бүтээлийн цомог

5.1л. Монгол зургийг орон зайтай дүрслэх аргыг жишээн дээр тайлбарлах	Сурах бичгээс: - Ардын зураач Н.Цүлтэм “Үүлэн чуулган” бүтээлийн үүлсын өнгийг ажиглах. - Монгол зурагт хүнд өнгөөс хөнгөн рүү, хөнгөн өнгөөс хүнд рүү шатлан дагнаасалдаг үндсэн аргатай танилцах. <i>/Энэ аргаас сайн суралцвал монгол зургийг орон зай болгон зурж чадна. Дагнаасыг хээ угалзанд шатлан зурваслаж дагнаасалдаг бол монгол зурагт зурвасын заагуудыг уусган дагнаасалдаг ялгаатай болохыг анхаарах нь чухал./</i> - Үүлэн хээнээс санаа авч уулсыг дээрх аргаар зохион зурж, өнгө дагнаас гарган будаж турших, сэтгэгдлээ илэрхийлэх.	Сурах бичиг, зургийн дэвтэр, гуаш, усан будаг, бийр, холигч, устай сав, харандаа, баллуур
---	--	---

5.2 ТЕХНОЛОГИ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.2а. Цаас дахин боловсруулан ашиглах талаар жишээн дээр тайлбарлах	- Цаасны зориулалт, хэрэглээтэй холбоотой асуудал дэвшүүлэн ярилцах Ярилцлагын чиглэл: - Цаас хаанаас хэрхэн үүсч бий болсон вэ? - Цаасыг ямар зориулалтаар хэрэглэдэг вэ? - Хэрэглээнээс гарсан цаасаа яах вэ? - Цаасны зохисгүй хэрэглээ ямар асуудал үүсэх вэ? - Цаасыг дахин боловсруулах ашиглах талаар зураглал хийж жишээгээр тайлбарлах - Цаасыг дахин боловсруулан ашиглахын ач холбогдлыг хэлэлцэх - Хэрэглээнээс гарсан цаасыг ашиглан хэрэгцээт зүйл хийх санаа гаргах - Өөрийн гаргасан санаа, бүтээл хийх аргаа бусаддаа танилцуулах <i>/Багшийн анхаарах зүйл: Багш тухайн агуулгыг тогтвортой хөгжлийн зорилт, агуулгатай уялдуулан хэрэгжүүлэх бүрэн боломжтой/.</i>	Зурагт үзүүлэн, видео бичлэг Ажлын хуудас Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 48-49
5.2б. Цаасыг нугалах, хуйлах аргаар чимэглэлийн бүтээл хийх	- Цаас нугалах, хуйлах аргаар төрөл бүрийн дүрс бүтээх зурган дарааллыг харж ажиглах - Өнгийн цаасан дээр ижил хэмжээтэй дугуй дүрсүүдийн гортиг ашиглан зурж, хайчлах - Хайчилж бэлтгэсэн дугуй дүрсийг 8 тэнцүү хэсэгт үүсгэн нугалах - Нугалсан мөрийн дагуу сэтэлж хайчлах - Хэсэг тус бүрийг нарийн харандаа ашиглан конус хэлбэр үүсгэн хуйлан наах аргаар бүрдэл хэсгүүдийг бэлтгэх - Бүрдэл хэсгүүдийн нийлүүлэн холбож чимэглэлийн бүтээл хийх - Чимэглэлийн материалууд ашиглан бүтээлийн гадаад үзэмж, харагдах байдлыг хөгжүүлэх - Цаас нугалах аргаар бие даан чимэглэлийн бүтээлийн шинэ санаа гаргах	Шугам, харандаа, өнгийн цаас, хайч Цаас нугалах, хуйлах аргыг харуулсан зурагт үзүүлэн Чимэглэлийн материалууд Хайч, цавуу Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 24-25

	– Санаагаа хэрэгжүүлэх арга барилаа турших – Бүтээлээ хийх, танилцуулах <i>/Багшийн анхаарах зүйл: Тухайн агуулгыг шинэ жилийн баяр угтан хэрэгжүүлэх нь тохиромжтой. Сурагчид өөрсдийн хийсэн чимэглэлээр сургууль, ангиа чимэглэж болно/.</i>	
5.2в. Нимгэн кардон хуйлж ирмэгээр нь зөрүүлэн наах аргаар цилиндр, конус биет бүтээх	– Геометрийн энгийн биетүүдийн талаар өмнөх мэдлэгээ сэргээн ярилцах – Нимгэн цаасаар цилиндр, конус биетийг өөрийн аргаар бүтээхийг оролдох турших – Биетийг бүтээх явцад үүссэн асуудал, бэрхшээл түүний шийдвэрлэх арга замыг хэрхэн эрэлхийлсэн талаараа тайлбарлах – Нимгэн кардон хуйлж ирмэгээр нь зөрүүлэн наах аргаар цилиндр, конус биет бүтээх – Бүтээсэн цилиндр, конус биетийг өнгийн цаас, сувс, тууз зэрэг чимэглэлийн материалууд, өнгийн будаг ашиглан хийх бүтээлийн санаа гаргах <i>/Багшийн анхаарах зүйл: Нимгэн цаасаар цилиндр, конус биетийг өөрийн аргаар бүтээх ба тулгамдсан асуудлаа хэрхэн өөрөө шийдвэрлэж байгааг багш анзаарах, арга замаа олоход нь асуултаар чиглүүлэх хэрэгтэй/.</i>	Цагаан цаас Картон цаас Шугам, харандаа, хайч, цавуу Дэвтэр, үзэг харандаа Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 12-13
5.2г. Цилиндр, конус, тэгш өнцөгт биет (шоо, параллелопепид)-ийн бүрдэл хэсгийн тоог нэмэх, хасах аргаар загварчилж бүтээл хийх	– Цилиндр, конус, тэгш өнцөгт биетүүдийн дэлгээсийг судлах, байгуулах – Шоо, параллелопепид, цилиндр, конус хэлбэртэй эд зүйлүүдийг харьцуулах, ялгааг ажиглаж ярилцах – Дэлгээс ашиглан өгөгдсөн хэмжээг томсгох, багасгах аргаар биетүүд бүтээх – Бүтээсэн биетүүдээ зохиомжлон өрж, холбох аргаар загвар бүтээх, хөгжүүлэх – Загвараа бусаддаа тайлбарлах <i>/Багшийн анхаарах зүйл: Багш тухайн агуулгыг хэрэгжүүлэхдээ сурагчдыг багаар зохион байгуулж болно. Баг тус бүр хийх биетээ сонгон, өгөгдсөн хэмжээг томсгох, багасгах аргаар өөр өөр хэмжээтэй нэг төрлийн биетүүд бүтээнэ. Хэмжээний хувьд өөр биетүүдээ зохиомжлон өрж наан загвар бүтээнэ. Загвараа багаараа ярилцан хамтран чимэглэж болно/.</i>	Цагаан цаас Картон цаас Шугам, харандаа, хайч, цавуу Дэвтэр, үзэг харандаа Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 12-13
5.2д. Автомашины загварын хэлбэрийг өөрчлөх аргаар зориулалтыг тодорхойлох	– Техникийн загварын ангилал болон онгоц, машиныг анх хэн, хэрхэн зохион бүтээснийг судлах, мэдээлэлд тулгуулан ярилцах – Зургаар өгсөн техникийн загваруудын материал, хийх аргыг тайлбарлах – Төрөл бүрийн материал ашиглан автомашины загварууд хийх	Хаягдал материал, хайрцаг, бөглөө Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 56-57

	– Хийсэн загваруудын хэлбэрийг өөрчлөн төрөл бүрийн зориулалтын автомашин болгон хувиргах – Автомашины төрөл, зориулалтыг хийсэн загваруудаа харьцуулах – Автомашины зориулалтыг тодорхойлох – Өмнөх туршлагаа ашиглан хөдөлгүүр хийж турших – Хийсэн загваруудаа улам сайжруулах <i>/Багшийн анхаарах зүйл: Төрөл бүрийн зориулалтын автомашин хийх замаар автомашины төрөл, зориулалтыг тодорхойлох юм. Мөн төрөл бүрийн материал ашиглан загвараа хийж байгаа учир тэдгээр материалуудыг хэрхэн холбох арга технологийг багш туршсан байх ба материал, багаж хэрэглэгдэхүүнтэй ажиллах аюулгүй ажиллагааг сануулж байх хэрэгтэй/.</i>	
5.2е. Байгалийн материал (боргоцой, чулуу)-ын хэлбэрийг ашиглан бүтээл хийх	– Сурагч бүр боргоцой, чулуу, самрын үр, тариа буудай зэрэг жижиг зүйлүүдийг түүж цуглуулах – Боргоцой, жижиг чулуу зэргийг баримлын шавар ашиглан холбож турших, өнгө ялган будах – Цуглуулсан материалуудаа ашиглан баримлын шавраар холбох, будаж чимэглэх аргаар тоглоом, бэлэг дурсгалын зүйл хийх. – Цуглуулсан байгалийн материалуудаа ашиглан янз бүрийн амьтан зохион бүтээж урлах <i>/Багшийн анхаарах зүйл: Байгалийн материал цуглуулах ажлыг анги хамт олноор аялал хийж, байгальтай зөв зохистой харьцаж, мод, бутнаас тасдахгүй байх, байгалиа хайрлан хамгаалах төлөвшил олгоход чиглүүлнэ/.</i>	Зурагт болон бодит үзүүлэн, Жижиг чулуу, боргоцой, мөчир зэрэг байгалийн материалууд Баримлын шавар Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 16-17
5.2ж. Цаасан зуурмагаар баримал, шуумал хийх	– Цаасан зуурмаг бэлтгэх аргатай танилцах – Цаасан зуурмаг бэлтгэх – Цаасыг дахин боловсруулахтай холбон ярилцах – Бэлгэсэн цаасан зуурмагийг бөөрөнхийлж зүүлт, тоглоом, аяга, таваг, хуруун хүүхэлдэй зэргийг өөрсдөө сонгон хийх – Зуурмагаар хийсэн биетүүдийг усан будгаар будаж чимэглэх – Цаасан шуумал хийх аргатай танилцаж, туршиж хийх – Цаасан зуурмаг болон шуумлын аргаар хийсэн бүтээлүүдээ будаж, чимэглэх – Хийсэн бүтээлүүдээ үзэсгэлэнд тавихад бэлтгэх – Өөрийн болон бусдын бүтээлийн талаар ярилцах, тайлбарлах, үнэлэлт дүгнэлт өгөх – Цаасыг хийдэг, түүнийг дахин боловсруулахтай холбон дэвтэртээ дүгнэж бичих <i>/Багшийн анхаарах зүйл: Багш тухайн агуулгыг тогтвортой хөгжлийн зорилт, агуулгатай уялдуулан хэрэгжүүлэх бүрэн боломжтой/.</i>	Цаасан зуурмаг бэлтгэх аргыг тайлбарласан үзүүлэн Хуучин сонин, хаягдал цаас, ариун цэврийн цаас Тараган цавуу эсвэл обойны цавуу Усан будаг Цаасан зуурмагаар хийсэн бүтээлийн бодит үзүүлэн Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 52-53

5.2з. Цаасан тавагны хэлбэрийг өөрчлөх аргаар малгайн загвар бүтээх	– “Малгайны баяр” гэсэн хүрээнд бүтээл хийх – “Малгайны баяр” сэдвийн хүрээнд хаягдал материал ашиглан хийж болох бүтээлийн санаагаа оюуны зураглалын аргаар илэрхийлэх, тайлбарлах – Цаасан тавгийг хэрхэн загварчлахаа төлөвлөх – Төлөвлөлтийн дагуу тавагны хэлбэрийг өөрчлөн загварчлах аргаар малгай загвар гаргах – Малгайн загварыг чихрийн цаас болон бусад материалаар чимэглэх – Малгайны баяр зохион байгуулах – Өөрсдийн хийсэн малгайгаа өмсөж оролцох ба хийх арга, онцлогийг танилцуулах – Үнэлгээ, дүгнэлт өгөх <i>/Багшийн анхаарах зүйл: Сурах бичиг дээрх загвараас санаа авч хийж болох ба өөрийхөөрөө баяжуулан чимэглэх боломжийн сурагчдад нээлттэй үлдээх хэрэгтэй. Малгайны баяр дээр сурагч бүр хийсэн бүтээлээ өмсөж, барьж зургаа авахуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж болох юм/.</i>	Цаасан таваг, аяга хайч, цавуу, өнгийн будаг дэвтэр, үзэг, харандаа Малгай хийх заавар Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 44-45
5.2и. Энгийн гар оёдлын төрлүүдийг зөөлөн эдлэл хийхдээ ашиглах	– Гар оёдолд хэрэглэгдэх багаж хэрэгслүүдийн хэрэглээг тайлбарлах – Хувцас, оёмол эдлэлүүдийг оёсон оёдлуудыг судалж, ярилцах – Гар оёдлоор оёх үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг тайлбарлан ярилцах – Жижиг зүйлүүд хийх даавуун уутны загваруудтай танилцах, загвар зохиож зурах – Энгийн гар оёдлууд болох хөших, шаглах, хөвөрдөх, захлах оёдлуудаар оёж турших – Өөрийн болон бусдын хувцсанд өлгүүр оёх – Дуувуун уутны эсгүүрийн зургийг зурах, байгуулах, бэлтгэх – Даавуун уут эсгэж, оёх – Даавуун уутыг чимэглэлийн материалууд ашиглан чимэглэх <i>Багшийн анхаарах зүйл: Гар оёдлоор оёх үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг байнга анхааруулах хэрэгтэй.</i> <i>Үүнд:</i> – Зүүг амандаа зууж болохгүй – Зүүг тусгай хатгуурт хатгаж хэвших – Хайчийг тусгай уутанд хийх – Хайчийг бусдад дамжуулахдаа бариулаар нь өгөх – Хайчийг ангайлган тавьж болохгүй.	Сэмрэлт багатай, биетэй, цулгай өнгийн даавуу /Гал тогооны 3 өнгийн алчуур/ Дэвтэр, үзэг, харандаа, өнгийн харандаа Хөших болон шидэх оёдлыг хэрхэн зөв оёх зурагт үзүүлэн Зүү, утас, хайч Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 28-29

5.2к. 3-4 төрлийн орц найрлагатай хачиртай талх бэлтгэх	– Талх, хиам, өргөст хэмх, улаан лооль гэх мэт хачир хийх бага зэрэг хүнсний зүйлүүдийг харах, үнэрлэх, амтлах эрхтнүүдээрээ мэдэрч, ярилцах – Муудсан эсэхийг шалгана. – Ямар хүнсний бүтээгдэхүүнд ямар амин дэмээр баялаг байдгийг уншиж судлах – Хачиртай талх бэлтгэх зарим аргуудын талаар мэдээлэл цуглуулах, хамтран хийж турших – Хачиртай талх хийх жор өөрсдөө зохиож, дэвтэртээ бичих – “Миний зохиосон хачиртай талх” сэдвийн дор багаараа хамтран хачиртай талх бэлтгэх – Хийсэн хачиртай талхаараа ширээ засаад бүгдээрээ амталгаа хийх. – <i>Багшийн анхаарах зүйл:</i> Хоол хүнс бэлдэх үедээ аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах болон хүнсний эрүүл ахуйн наад захын шаардлагыг хэрхэн хангаж байгаад багш хяналт тавих хэрэгтэй.	Хутга, мах ногоо хэрчих мод, талх, хачир хийх хүнсний бүтээгдэхүүнүүд лууван, чанасан өндөг Салфетка Цаасан аяга, таваг Дэвтэр, үзэг, харандаа Д, Цэдэн-Иш нар. Дүрслэх урлаг, технологи. 5 дугаар ангийн сурах бичиг хуудас 40-41
5.2л. Сургууль дээрх ажил мэргэжлүүдийг нэрлэх онцлог болон нийтлэг талыг жишээгээр тайлбарлах	– Сургууль дээрх ажил, мэргэжлүүдийг нэрлэх жагсаан бичих – Ажил болон мэргэжлийн онцлог болон нийтлэг талыг “<i>Венийн диаграмм</i>”-н аргаар харьцуулан тайлбарлах – Сургуулийн хүрээнд ажил мэргэжлүүдийн хувьд ялгаатай хүмүүстэй зохистой харилцах талаар хэлэлцэх <i>Багшийн анхаарах зүйл:</i> Багш сурагчдад тухайн агуулга, даалгавартай холбоотой үйл ажиллагааг удирдан явуулахдаа хүмүүсийн ажил мэргэжлийн талаарх хэвшмэл ойлголтод баригдахгүй байхыг анхаарна. Өөрөөр хэлбэл, ажил мэргэжлийн талаарх хэлэлцүүлгийг чиглүүлэхдээ, тодорхой нэг хүйсэд л хамаарах шинжтэй эмэгтэй эсвэл эрэгтэй хүний мэргэжил гэсэн жендэрийн хэвшмэл ойлголтоос зайлсхийх хэрэгтэй. Ажил мэргэжлүүдтэй холбоотой зурагт үзүүлэн, видео бичлэгийг дараах хаягаар татаж аваарай. https://www.youtube.com/results?search_query=Jobs+and+Occupations	Ажил мэргэжлийн харуулсан зурагт үзүүлэн, видео бичлэг Ажлын хуудас Ажил мэргэжил: А ба Б-гийн онцлог АБ хэсэгт нийтлэг тал

Тэмдэглэл

